



БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН
ЯАМ



БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН
ДЭД ХАВСРАЛТ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ДАВХАРДАЛ, ЗӨРЧИЛ,
ХИЙДЛИЙН СУДАЛГАА



ЗАХИАЛАГЧ: БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ



ГҮЙЦЭТГЭГЧ: МОНГОЛЫН БАРИЛГЫН ИНЖЕНЕРҮҮДИЙН
ХОЛБООНЫ ЗӨВЛӨХ БАГ

Улаанбаатар хот
2023 он



БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН
ЯАМ



БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ДЭД ХАВСРАЛТ

БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ДАВХАРДАЛ, ЗӨРЧИЛ, ХИЙДЛИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ЗАХИАЛАГЧ: БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ

ГҮЙЦЭТГЭГЧ: МОНГОЛЫН БАРИЛГЫН ИНЖЕНЕРҮҮДИЙН
ХОЛБООНЫ ЗӨВЛӨХ БАГ:

А.Ариунболд /Зөвлөх инженер, Багийн ахлагч/
Б.Бямбажав /Зөвлөх Инженер/
Э.Ганзориг /Зөвлөх инженер/
Б.Гантулга /Зөвлөх инженер/
М.Гандорж /Мэргэшсэн инженер, нарийн бичиг/
Г.Ган-өлзий /Мэргэшсэн инженер/
Б.Мөнхбаатар /Мэргэшсэн инженер/
Ц.Жавхлан /Мэргэшсэн инженер/
А.Дэлгэрмаа /Ахлах хуульч, өмгөөлөгч/
Б.Болормаа /Эрх зүйч/
А.Одхүү /Эрх зүйч/
Б.Энх-учрал /Эрх зүйч/
Ч.Тавансахъяа /Эдийн засагч, судлаач/
Э.Одгэрэл /Мэргэшсэн инженер, судлаач/
Н.Гүндэгмаа /Эдийн засагч, туслах/

Улаанбаатар хот
2023 он

**Барилгын салбарын хууль, эрх зүйн орчны тойм болон
БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ДАВХАРДАЛ, ЗӨРЧИЛ, ХИЙДЛИЙН
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

| Агуулга | Хуудасны дугаар |
|--|-----------------|
| Товчилсон үгийн жагсаалт | 3 |
| НЭГ. ТАНИЛЦУУЛГА | 4 |
| • Судалгааны арга, аргачлал: | 4 |
| • Хуулийн давхардал, зөрчил, хийдлийг илрүүлэх зорилгоор эрх зүйн актыг шалгах дараалал: | 4 |
| • Судалгааны хамрах хүрээ, хязгаар: | 4 |
| • Цуглуулсан эрх зүйн актууд: | 5 |
| ХОЁР. БАРИЛГЫН САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН /тойм/ | 6 |
| • Барилгын хуулиудын талаарх түүхэн тойм | 6 |
| • Барилгын тухай хууль | 6 |
| • Хуулийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа | 6 |
| • Нэмэлт, өөрчлөлт орсон байдал: | 6 |
| • Барилгын салбарын эрх зүйн баримт бичгүүд | 8 |
| ГУРАВ. ДАВХАРДАЛ, ЗӨРЧИЛ, ХИЙДЛИЙН СУДАЛГАА | 11 |
| • 3.1. ДАВХАРДАЛ | 11 |
| 7.1.2.Тухайн хуульд байгаа зохицуулалтыг уг хуульд болон бусад хуульд бичвэрийн, эсхүл агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан эсэх. | 11 |
| • 3.2. ЗӨРЧИЛ | 16 |
| 7.2.1.тухайн зохицуулалт нь хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх; | 16 |
| 7.2.5.хуульд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн болон бусад хуулийн нэр томъёотой зөрчилдөж байгаа эсэх; | 17 |
| 7.2.7. Хуульд заасан эшлэл алдаатай эсэх | 18 |
| 7.2.8.тухайн хуульд бусад хуулиас авсан эшлэлийн дугаар нь нөгөө хуульд байгаа зохицуулалттай нийцэж байгаа эсэх; | 19 |
| 7.2.13.Хуулийн зүйл, заалт нь тухайн хууль болон өөр хуулийн заалттай зөрчилдөж буй эсэх. | 22 |
| • 3.3. ХИЙДЭЛ | 27 |
| 7.3.2.тухайн хуульд тодорхой харилцааны нарийвчилсан зохицуулалтыг батлах эрхийг төрийн бусад байгууллагад шилжүүлсэн бол уг нарийвчилсан зохицуулалт батлагдсан эсэх; | 27 |
| 7.3.4.тодорхой эрх, үүргийг хэрэгжүүлэх этгээд нь тодорхой эсэх; | 27 |
| 7.3.6.хуульд заасан хориглосон зохицуулалт нь түүнийг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх; | 28 |
| 7.3.8.хуульд байх шаардлагатай зохицуулалт тусгагдсан эсэх; | 29 |
| ДӨРӨВ. НЭГДСЭН ДҮН, САНАЛ ДҮГНЭЛТ | 42 |
| • НЭГДСЭН ДҮН | 42 |
| • САНАЛ, ДҮГНЭЛТ | 44 |
| ➤ Хуулийн давхардлын талаар | 44 |
| ➤ Хуулийн зөрчлийн талаар | 45 |
| ➤ Хуулийн хийдлийн талаар | 46 |
| ХАВСРАЛТ 1. БАРИЛГЫН САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЖАГСААЛТ | 49 |
| ХАВСРАЛТ 2. СУДАЛГААНЫ АЖЛЫН АРГАЧЛАЛ | 54 |

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

- БНБД – Барилгын норм ба дүрэм
- БОНХАЖСайд- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд
- БтХ – Барилгын тухай хууль
- БХБЯ – Барилга, хот байгуулалтын яам
- БХБСайдын- Барилга, хот байгуулалтын сайдын
- БХТ – Барилгын хөгжлийн төв
- БХБ-ын – Барилга, хот байгуулалтын
- ИТХ – Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
- ЗГ – Засгийн газар
- ЗТ- Зам тээвэр
- ЗТХСайдын – Зам, тээврийн хөгжлийн сайдын
- ЗТБХБСайдын – Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын
- МУДБХСайдын – Монгол Улсын Дэд бүтцийн хөгжлийн сайдын
- ОХУ – Оросын Холбооны Улс
- ТЗБ – Төрийн захиргааны байгууллага
- ТЗТБ – Төрийн захиргааны төв байгууллага
- УИХ – Улсын Их Хурал
- СӨХЭБНЗОСДӨЭХТХ – Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль
- ЭХСайдын – Эрчим хүчний сайдын

Удиртгал

“Монголын барилгын инженерүүдийн холбоо” ГҮТББ нь 2023.07.18-ны өдөр БХТ-тэй Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан Барилгын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлж, Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын/нэмэлт өөрчлөлтийн төсөл боловсруулах, хуулийн төслийн бүрдүүлбэрийг бэлтгэх ажлыг эхлүүлсэн. Зөвлөх баг уг ажлын хүрээнд 2016 оны 2-р сарын 6-нд батлагдсан “**Барилгын тухай хууль**”¹-ийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлын хүрээнд дэд тайлан болох **Барилгын тухай хуулийн давхардал, зөрчил, хийдлийн тайланг** боловсруулсан болно.

Судалгааны арга, аргачлал:

- Энэхүү судалгаанд баримт бичиг судлах; задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх; харьцуулалт хийх /synopse/ аргыг ашиглав.
- Барилгын тухай хуулийн давхардал, зөрчил, хийдлийг тогтоох судалгааны ажилд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 84 дүгээр тушаалаар батлагдсан “Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах ажлыг хийх аргачлал”²-ыг удирдлага болгов.
- Энэхүү судалгаанд 2018 онд Хууль зүй, дотоод хэргийн яам, Барилга хот байгуулалтын яам хамтран Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчныг баталгаажуулах” төслийн дэмжлэгтэйгээр барилгын чиглэлийн 11 хуулийн хийдэл, зөрчил, давхардлыг тогтоох, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах ажлын хүрээнд боловсруулсан “Барилгын тухай хуулийн давхардал, зөрчил, хийдлийн судалгаа”-нд³ суурилан нэмж, сайжруулан боловсруулав.⁴

Хуулийн давхардал, зөрчил, хийдлийг илрүүлэх зорилгоор эрх зүйн актыг шалгах дараалал:

1. Барилгын тухай хуулийн дотоод давхардал, зөрчил, хийдлийг илрүүлэх,
2. Барилгын тухай хуулийг бусад хуультай харьцуулж давхардал, зөрчил, хийдлийг илрүүлэх,

Судалгааны хамрах хүрээ, хязгаар:

- Барилгын тухай хуультай шууд холбоотой хууль, эрх зүйн бусад актыг нэгтгэн цуглуулах, түүнд ангилал хийх;
- Барилгын тухай хуулийг эрх зүйн бусад акттай харьцуулж уг хуульд давхардал, зөрчил, хийдэл байгаа эсэхийг судлах;
- Илэрсэн давхардал, зөрчил, хийдлийг хуулийн зүйл, заалт тус бүрээр гарган саналыг Захиалагч талд шилжүүлэх;

¹<https://legalinfo.mn/mn/detail?lawId=11705>

² Аргачлалыг энэхүү тайланд Хавсралт – 2-оор оруулав.

³ Энэхүү судалгааны хүрээнд Барилгын тухай хуулийг холбогдох бусад хуультай харьцуулан судалж, давхардал-6, зөрчил-4, хийдэл-2 буюу нийт 12 давхардал, зөрчил, хийдлийг тогтоосон байв.

⁴ Эх сурвалж: БХБЯ

Цуглуулсан эрх зүйн актууд:

Барилгын тухай хуулийн давхардал, зөрчил, хийдлийг тогтоох ажлын хүрээнд Барилгын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд харьцуулан судаллаа.

Барилгын хуулиудын талаарх түүхэн тойм

1992 онд байгуулагдсан Барилга, хот байгуулалтын яамны удирдлагууд ОХУ-ын Хот байгуулалтын /“Градостроительный кодекс”/ тухай хуулийг ашиглан Хот байгуулалтын тухай хуулийн төсөл, Барилгын тухай хуулийн төслийг боловсруулан 1993.08.03-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн мэдүүлсэн байдаг. Барилгын тухай Монгол Улсын хуулийг анх 1998 оны 8 дугаар сарын 7-ны өдөр УИХ баталсан. Энэ хуулийн зорилт нь инженерийн хийцтэй барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын материал үйлдвэрлэх, барилгын ажил гүйцэтгэх, ашиглах, техникийн хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад орших бөгөөд 7 бүлэг, 19 зүйлтэй байсан. Энэ хуулийг 2008 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон.

Улмаар Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2008 оны 2 дугаар сарын 05-ны өдөр баталсан бөгөөд тус хуулийн зорилт нь барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын материал үйлдвэрлэх, барилгын ажил гүйцэтгэх, ашиглах, техникийн хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршиж байв. Барилгын тухай хууль нь 7 бүлэг, 26 зүйлтэй байсан ба уг хуулийг 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар хүчингүй болсонд тооцсон.

БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬ⁵**Хуулийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа**

Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй Барилгын тухай хууль нь 2016 оны 2 дугаар сарын 5-нд /шинэчилсэн найруулга/ батлагдсан. Хууль нь 9 бүлэг, 50 зүйлтэй. Барилгын тухай хуулийн зорилт нь барилгын үйл ажиллагаа эрхлэх, барилгын материал үйлдвэрлэх, барилгын ажил гүйцэтгэх, түүнд хяналт тавих, ашиглалтад оруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Нэмэлт, өөрчлөлт орсон байдал

Барилгын тухай хууль 2016 онд батлагдсанаас хойш 2023 оны 9 дүгээр сарын байдлаар нийтдээ 16 удаа нэмэлт, өөрчлөлтүүд оруулсан байна. Үүнд дараах нэмэлт, өөрчлөлтүүд орсон байна:

| № | Нэмэлт, өөрчлөлт орсон огноо | Товч тайлбар |
|---|------------------------------|---|
| 1 | 2017-02-02 | Хуулийн 12.1.15 болон 46.2 дахь хэсэгт “Гамшигт аюулт үзэгдлийн” гэж өөрчилсөн. |
| 2 | 2017-05-11 | Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсонтой холбогдуулан БтХ-ийн “Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага” гэх 50-р зүйлд Зөрчлийн зохицуулалт оруулсан. |

⁵ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11705>

| | | |
|----|------------|--|
| 3 | 2017-05-11 | Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсонтой холбогдуулан БТХ-ийн 4.1.1-д “Зам гүүр” гэснийг хассан |
| 4 | 2020-04-24 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсонтой холбогдуулан БТХ-ийн 46.3-д “төрийн” гэж нэмсэн. |
| 5 | 2021-01-29 | 1. Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсонтой холбогдуулан хуульд 6.4, 23.7 болон 26.5 дахь хэсгийг нэмж оруулан, дээрх БТХ-ийн зохицуулах хэсгийг холбож өгсөн байна. 2. БТХ-ийн 32.1.5-д “Газрын тос боловсруулах үйлдвэр, түүхий тос дамжуулах хоолой” гэдгийг нэмсэн. |
| 6 | 2021-12-16 | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсантай холбогдуулан БТХ-ийн 33.1.7 хэсэгт “батлах” гэснийг “хэрэгжүүлэх” гэж өөрчилсөн. |
| 7 | 2021-12-17 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсонтой холбогдуулан 37.1.2 дахь хэсэгт өөрчлөлт орсон. |
| 8 | 2022-04-22 | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт , өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болж, БТХ-ийн 46.1.5-д “нийтийн аюулгүй байдалд хяналт тавих” агуулга бүхий зохицуулалт нэмсэн. |
| 9 | | БТХ-ийн 33.1.23-дах заалтыг, 32.1.5-д “ашиглалтад оруулах” гэснийг, 35.1.6-д “Энэ хуулийн 32.1.5, 33.1.23-т зааснаас бусад” гэж тус тус нэмсэн. |
| 10 | 2022-06-03 | БТХ-ийн 12.1.2-д “хөргөлт, агааржуулалтын систем нь озон задалдаг бодисыг орлуулах бодис ашигласан байх” гэснийг нэмсэн |
| 11 | 2022-06-17 | Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсонтой холбогдуулан 4.1.21 болон 20.3 дахь заалтуудад өөрчлөлт оруулсан. |
| 12 | 2022-11-11 | 1. БТХ-ийн 14.10, 19.2, 47.1, 47.2, 47.3, 49.1 дэх хэсэгт "улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий" гэснийг "асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв" гэж 2. 20.8 дэх хэсэгт барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага" гэснийг "асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн" гэж 3. 46.3-д "улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий" гэснийг "барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв" гэж, 4. 49.5-д "мэргэжлийн хяналтын" гэснийг "барилгын" гэж тус тус өөрчилсөн. |
| 13 | 2022-12-09 | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль хүчин төгөлдөр болсонтой холбогдуулан БТХ-д 33.1.24 дэх заалтыг нэмсэн. БТХ-ийн 33.1.24 дэх заалтын дугаарыг "33.1.25" гэж өөрчилсөн. |
| 14 | 2022-01-06 | Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсантай холбоотойгоор БТХ-д дараах томоохон өөрчлөлт бий болсон. Үүнд: 1. БТХ-ийн 19.3 дахь хэсэгт тусгай зөвшөөрлийг барилга байгууламжийн төвөгшил болон хуулийн этгээдийн тогтвортой байдлыг харгалзан шатлан ахиулж олгох зарчмыг нэмсэн. 2. БТХ-ийн 20.11-20.13 дахь хэсэгт тусгай зөвшөөрлийн өргөдөл нэмэлтээр хавсаргах баримт бичгийг оруулсан. 3. Мөн 28.7, 30.5 дахь хэсгийг нэмж оруулсан. 4. Мөн БТХ-ийн 28.5, 20.1, 27-р зүйл болон бусад холбогдох заалтуудад өөрчлөлт оруулсан. |
| 15 | 2023-06-16 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсноор БТХ-ийн 14.8 дахь хэсгийн “43.6-д гэснийг 42.6” гэж өөрчилсөн. |

| | | |
|----|------------|--|
| 16 | 2023-07-07 | Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсонтой холбогдуулан БТХ-ийн 32.1.5-аас “Төмөр зам” гэснийг хассан. |
|----|------------|--|

БАРИЛГЫН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД

Барилгын тухай хуулийн судалгааны хүрээнд эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем болох www.legalinfo.mn⁶ цахим сайтаас **Барилга** болон **барилгын** гэсэн түлхүүр үгээр хайлт хийхэд шууд болон шууд бус хамааралтай доорх хууль, дүрэм, журмууд олдож байна⁷. Үүнд:

- Хууль – 33
- УИХ-ын тогтоол – 4
- Олон улсын гэрээ – 1
- Ерөнхийлөгчийн зарлиг – 0
- УИХ-аас томилогддог байгууллага, түүнтэй адилтгах албан тушаалтны шийдвэр – 0
- Үндсэн хуулийн цэцийн шийдвэр – 0
- Улсын дээд шүүхийн шийдвэр – 0
- Улсын дээд шүүхийн тогтоол – 0
- Засгийн газрын тогтоол – 13
- Сайдын тушаал – 50
- Шадар сайдын тушаал – 2
- Агентлагийн даргын тушаал – 0
- Аймаг, нийслэлийн засаг даргын захирамж – 0

Дээр дурдсан хууль, эрх зүйн актуудаас тус хуульд шууд хамаарах дараах хууль, эрх зүйн актууд байна. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль (1992),
- Иргэний хууль (2002),
- Орон сууцны тухай хууль (1999),
- Газрын тухай хууль (2002),
- Хот байгуулалтын тухай хууль (2008),
- Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль (1993),
- Хот, суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль (2011),
- Эрчим хүчний тухай хууль (2001),
- Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль (2015),
- Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль (1999),
- Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай (2003),
- Геодези зураг зүйн тухай хууль (1997),
- Газрын хэвлийн тухай хууль (1998),
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (2021),
- Зөрчлийн тухай хууль (2017),
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (2023),
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль (2017);

⁶ <https://legalinfo.mn/mn>

⁷ Барилгын салбарын хууль тогтоомжийн жагсаалтыг энэхүү тайланд Хавсралт – 1-ээр оруулав.

- Галын аюулгүй байдлын тухай хууль (2015),
- Гамшгаас хамгаалах тухай хууль (2017),
- Хог хаягдлын тухай хууль (2017),
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай (2020),
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тухай хууль (2016),
- Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль (2021),
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хууль (2018)
- Барилгын салбарт хамаарах бодлогын баримт бичгүүд,
- Барилгын норм ба дүрэм,
- Стандарт.

| ХУУЛЬ | ЗОХИЦУУЛАЛТ |
|---|--|
| Монгол Улсын Үндсэн хууль 16 дугаар зүйл | <ul style="list-style-type: none"> • эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй; • хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө; |
| Иргэний хуулиар | <p>Иргэний хуулиар бусдын барилга дээр барилга байгууламж барих эрх, Хөршийн нөлөөллийг хориглон хязгаарлах буюу хориглон хязгаарлаж үл болох, Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчийн эрхийг хязгаарлах эрх /сервитут/, үүргийн харилцаа, үүрэг дуусгавар болох, Нийтийн зориулалттай орон сууц өмчлөх эрх, Сууц өмчлөгчдийн холбоо, Холбоог татан буулгах, Орон сууц дангаар өмчлөх эрх үүсэх, ажил гүйцэтгэх гэрээний зохицуулалт, Барилга байгууламж барих, ашиглах явцад учирсан гэм хорыг хариуцах, Орчин тойрондоо аюултай үйл ажиллагаа болон орчин тойрондоо аюултай бусад зүйлээс учирсан гэм хорыг хариуцах талаар,</p> |
| Орон сууцны тухай хуулиар | <p>Орон сууцны талаарх төрийн байгууллагуудын бүрэн эрхийг тогтоож, орон сууц төлөвлөх, орон сууц хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх нийтийн зориулалттай орон сууцны байшингийн зориулалтыг өөрчлөх болон орон сууц ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахаар,</p> |
| Газрын тухай хуулиар | <p>Газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах болон түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулахаар,</p> |
| Хот байгуулалтын тухай хуулиар | <p>Монгол Улсын хот байгуулалтын бодлогын хүрээнд хүн ам, нутагшилт суурьшлын зохистой бүтэц бүрдүүлэх, хот, тосгоныг төлөвлөлтийн дагуу барьж байгуулахад төр, байгууллага, иргэний харилцааны зохицуулалтыг,</p> |
| Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиар | <p>Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгон, түүний эдэлбэр газар, нийгэм эдийн засгийн үндэс, хот, тосгоны удирдлагаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, бусад байгууллага, оршин суугчтай харилцах харилцааг,</p> |
| Хот, суурины ус хангамж, | <p>Хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан</p> |

| | |
|--|--|
| ариутгах татуургын ашиглалтын тухай хуулиар | зайлуулах, цэвэрлэх зориулалттай инженерийн барилга байгууламжийг өмчлөх, ашиглах талаар, |
| Эрчим хүчний хуулиар | Эрчим хүчний нөөцийг ашиглан эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагаа эрхлэх, эрчим хүчний барилга байгууламж барих болон эрчим хүчийг хэрэглэх талаар, |
| Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулиар | Бүх төрлийн кадастрын зураглал үйлдэх, газрын кадастр эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар, |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тухай хуулиар | Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрх, түүнийг хангах, хэрэгжүүлэх, хамгаалах талаар төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, оролцоо, баримтлах зарчмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахаар, |
| СӨХЭЗБНЗОСД ӨЭХ-ийн тухай хууль | Сууц өмчлөгчдийн холбооны зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлох, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн өмчлөл, эзэмшил, ашиглалт, хамгаалалттай холбоотой харилцааг зохицуулахаар, |
| Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулиар | Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын тусгай болон бусад чиг үүргийг тогтоох, хөгжлийн бодлого, удирдлага, зохион байгуулалтын онцлог, дагуул хот, эдийн засгийн тусгай бүс, төрийн дээд болон төрийн захиргааны төв байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгж, хуулийн этгээд, байгууллагатай харилцахтай холбогдсон харилцааг зохицуулахаар, |
| Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулиар | Хот, суурин газрын барилгажсан хэсэг, нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, дахин төлөвлөн барилгажуулахтай холбогдон үүсэх харилцааг тус тус зохицуулж байна. |

3.1. ДАВХАРДАЛ

7.1.2. тухайн хуульд байгаа зохицуулалтыг уг хуульд болон бусад хуульд бичвэрийн, эсхүл агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан эсэх.

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | |
|--|---|--|
| 1. | <p>37 дугаар зүйл чиг. Захиалагчийн үүрэг 37.1.Барилгын ажлын захиалагч дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ: 37.1.15.барилга байгууламжийн баримт бичгийг ашиглалтын хугацаанд хадгалж, баяжуулалт хийх;</p> | <p>46 дугаар зүйл. Барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигчийн үүрэг 46.1.Барилга байгууламжийн ашиглалтын явцад өмчлөгч, эзэмшигч дараахь үүргийг хүлээнэ: 46.1.12.барилгын ашиглалтын хугацаанд барилга байгууламжийн баримт бичгийг баяжуулж, хадгалах;</p> |
| <p>Дүгнэлт: Хуулийн 37.1.15 болон 46.1.12-т захиалагчийн чиг үүргийг, барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигчийн чиг үүрэгт давхардуулсан байна. Ашиглагч нь барилгын хувийн хэргийн хөтлөлтийг хариуцдаг бөгөөд тодруулбал барилга ашиглалтад орсноор ашиглагч, өмчлөгч эзэмшигч уг асуудлыг хариуцдаг зохицуулалттай.</p> <p>Санал: Барилга ашиглалтад орсноор ашиглагч, өмчлөгч, эзэмшигч барилга байгууламжийн баримт бичгийг баяжуулж, хадгалах асуудлыг хариуцдаг. Иймд, хуулийн 37.1.15 дахь заалтыг хүчингүй болгох.</p> | | |

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | |
|--|--|---|
| 2. | <p>5 дугаар зүйл. Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг 5.1.Барилгын үйл ажиллагааг доор дурдсан норм, нормативын баримт бичгээр зохицуулна: 5.1.1.барилгын норм, дүрэм; 5.1.2.барилгын болон техникийн дүрэм, заавар, цомог, аргачлал; 5.1.3.стандарт.</p> | <p>5 дугаар зүйл. Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг 5.1.2.барилгын болон техникийн дүрэм, заавар, цомог, аргачлал;</p> |
| <p>Дүгнэлт: Хуулийн 5.1.1, 5.1.2-т барилгын дүрэм гэж агуулгын хувьд давхардсан зохицуулалт байна.</p> <p>Санал: Барилгын тухай хуулийн 5.1.2 дахь заалтаас “дүрэм” гэснийг хасах.</p> | | |

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | |
|---|--|--|
| | | |

| | | |
|---|--|---|
| 3. | 28 дугаар зүйл. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгох 28.2.3.зураг төсөл зохиогч хуулийн этгээдийн танилцуулга, улсын бүртгэлийн болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар; | 28 дугаар зүйл. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгох 28.3.Энэ хуулийн 28.2-т заасан баримт бичгээс гадна зураг төсөл боловсруулсан болон барилгын ажил гүйцэтгэх хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хавсаргана. |
| Дүгнэлт: Хуулийн 28.3 дахь хэсэгт зураг төсөл боловсруулсан хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хавсаргахаар заасан нь тус хуулийн 28.2.3 дахь хэсэгт заасан баримт бичгийн жагсаалттай давхардсан байна. | | |
| Санал: Хуулийн 28.3 дахь хэсгээс “зураг төсөл боловсруулсан болон” гэснийг хасах. | | |

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | |
|---|--|--|
| 4. | 37 дугаар зүйл. Захиалагчийн чиг үүрэг 37.1.Барилгын ажлын захиалагч дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ: 37.1.5.барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах; | 40 дүгээр зүйл. Барилгын ажил гүйцэтгэгчийн чиг үүрэг 40.1.Барилгын ажил гүйцэтгэгч дараахь чиг үүрэгтэй: 40.1.12.барилга байгууламжийн хийц, бүтээцийн даацын бат бэхийг барилгын ажлын үе шат бүрд лабораторийн шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулан баталгаажуулах; |
| Дүгнэлт, санал: Хуулийн 37.1.5 дахь заалтын захиалагчийн чиг үүрэг болон 40.1.12 дахь заалтын барилгын ажил гүйцэтгэгчийн чиг үүргийг агуулгын хувьд давхардуулан бичсэн байх тул талуудын чиг үүргийг тодорхой болгох үүднээс заалт тус бүрд уялдуулсан зохицуулалтыг хийж, өөрчлөлт оруулах. | | |

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | Эрчим хүчний тухай хууль 2001.02.01 |
|---|---|---|
| 5. | 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 4.1.16."барилга байгууламжийн зураг төслийн магадлал" гэж барилга байгууламжийн зураг төсөл, технологи, өргөх байгууламжийн сонголт, хот болон архитектур төлөвлөлт, үндсэн бүтээцийн бат бэхийн шийдэл барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлага, хэрэглэгчийн аюулгүй байдлыг хангасан эсэхэд дүгнэлт гаргах хараат бус, бие даасан мэргэжлийн үйл ажиллагааг; | 46 дугаар зүйл. Барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигчийн үүрэг 3.1.32."магадлал" гэж эрчим хүчний барилга байгууламж, түүнд шаардагдах техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон ажлын зураг, техник, технологи, нэгдсэн төсөв нь норм, дүрэм, стандартын шаардлага хангасан талаар мэргэшсэн шинжээчийн дүгнэлт гаргах ажиллагааг; |
| Дүгнэлт: Барилгын тухай хуулийн 4.1.16 болон Эрчим хүчний тухай хуулийн 3.1.32-т “магадлал”-ын талаарх нэр томъёоны тодорхойлолтыг агуулгын хувьд давхардуулан тодорхойлсон байна. | | |

Санал: Барилга байгууламжийн суурь зохицуулалтыг агуулж буй Барилгын тухай хуульд “зураг төслийн магадлал”-ын талаарх суурь тодорхойлолтыг найруулга, утга агуулгыг сайжруулах замаар үлдээж, Эрчим хүчний тухай хуульд Барилгын тухай хуулийг эшлэх.

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | Ойн тухай хууль 2012.05.17 /Шинэчилсэн найруулга/ |
|--|---|--|
| 6. | 40 дүгээр зүйл. Барилгын ажил гүйцэтгэгчийн чиг үүрэг 40.3.Барилга байгууламж барих, шинэчлэх, өргөтгөх, засварлах ажилд олон улсын болон үндэсний стандартын шаардлага хангаагүй, гарал үүсэл, тохирлын гэрчилгээгүй материал, бүтээгдэхүүн, эдлэхүүн болон барилгын хэв хашмалын тулаасанд мод хэрэглэхийг хориглоно. | 29 дүгээр зүйл. Ойд хориглох үйл ажиллагаа 29.1.9.барилга байгууламж барих, шинэчлэх, өргөтгөх, засварлах ажилд барилгын хэв хашмалын тулаасны зориулалтаар бөөрөнхий мод ашиглах; |
| Дүгнэлт: Барилгын тухай хуулийн 40.3 дахь хэсэгт заасан зохицуулалт Ойн тухай хуулийн 29.1.9-д заасан зохицуулалттай агуулгын хувьд давхардсан байна. | | |
| Санал: Барилгын тухай хуульд Ойн тухай хуулиас эшлэх. | | |

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | Автозамын тухай хууль 2017.05.11 /Шинэчилсэн найруулга/ |
|---|---|---|
| 7. | 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт 4.1.16."барилга байгууламжийн зураг төслийн магадлал" гэж барилга байгууламжийн зураг төсөл, технологи, өргөх байгууламжийн сонголт, хот болон архитектур төлөвлөлт, үндсэн бүтээцийн бат бэхийн шийдэл барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлага, хэрэглэгчийн аюулгүй байдлыг хангасан эсэхэд дүгнэлт гаргах хараат бус, бие даасан мэргэжлийн үйл ажиллагааг; | 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт 4.1.20."зураг төслийн магадлал" гэж авто зам, замын байгууламжийн зураг төслийн хийц, инженерийн шийдэл, тооцоо нь байгаль, цаг уур, газар орны нөхцөлд зохицож байгаа эсэх, замын хөдөлгөөний зохион байгуулалт, аюулгүй байдал нь авто зам, замын байгууламжийн норм, норматив, техникийн баримт бичгийн шаардлага хангасан эсэхэд мэргэжлийн дүгнэлт гаргах үйл ажиллагааг; |
| Дүгнэлт: Барилгын тухай хууль болон Авто замын тухай хуулийн 4 дүгээр зүйлд “зураг төслийн магадлал”-ын талаарх нэр томьёоны тодорхойлолтыг агуулгын хувьд давхардуулан тодорхойлсон байна. | | |
| Санал: Барилгын тухай хуульд “зураг төслийн магадлал”-ын талаарх суурь тодорхойлолтыг найруулга, утга агуулгыг сайжруулах замаар үлдээж, Авто замын тухай хуульд Барилгын тухай хуулийг эшлэх. | | |

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | Автозамын тухай хууль 2017.05.11 /Шинэчилсэн найруулга/ |
|----|--|---|
| 8. | 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт | 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт |

| | |
|---|--|
| <p>4.1.30."зураг төсөл" гэж барилга байгууламжийг төлөвлөх, барилгын ажил гүйцэтгэхэд шаардагдах загвар зураг, эх загвар зураг /эскиз/, техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон ажлын зураг, барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын төсөл, инженер хайгуулын судалгаа, инженер геологи, геодезийн зураглал, инженерийн тооцоо, өртгийн төсөв зэрэг баримт бичгийн иж бүрдлийг;</p> | <p>4.1.18."зураг төсөл" гэж авто зам, замын байгууламжийг барих, засварлах, шинэчлэхэд шаардагдах хайгуул, геологийн дүгнэлт, геодезийн хэмжилтийн тайлан, байгаль орчны судалгаа, нарийвчилсан зураг, техникийн шаардлага, өртгийн тооцооны нэгдсэн баримт бичгийг;</p> |
| <p>Дүгнэлт: Авто замын тухай хуулийн 4.1.18-д "зураг төсөл"-ын талаарх нэр томъёоны тодорхойлолтыг Барилгын тухай хуультай агуулгын хувьд давхардуулан тодорхойлсон байна.</p> <p>Санал: Барилгын тухай хуульд "зураг төсөл"-ын талаарх суурь тодорхойлолтыг найруулга, утга агуулгыг сайжруулах замаар үлдээж, Авто замын тухай хуульд Барилгын тухай хуулийг эшлэх.</p> | |

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | Автозамын тухай хууль 2017.05.11 /Шинэчилсэн найруулга/ |
|--|---|--|
| 9. | <p>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 4.1.31."зураг төсөл зохиогч" гэж барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах эрх бүхий хуулийн этгээдийг;</p> | <p>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 4.1.19."зураг төсөл зохиогч" гэж авто зам, замын байгууламжийн зураг, төсөв боловсруулах эрх бүхий хуулийн этгээдийг;</p> |
| <p>Дүгнэлт: Авто замын тухай хуулийн 4.1.19-д "зураг төсөл зохиогч"-ийн нэр томъёоны тодорхойлолтыг Барилгын тухай хуультай агуулгын хувьд давхардуулан тодорхойлсон байна. Үүнээс гадна Авто замын тухай хуульд "...авто замын байгууламжийн зураг, төсөв боловсруулах" гэсэн нь алдаатай болсон байна, учир нь зураг төсөл боловсруулах, төсөв зохион субъект нь тусдаа ойлголтууд юм.</p> <p>Санал: Барилгын тухай хуульд "зураг төсөл зохиогч"-ийн талаарх суурь тодорхойлолтыг найруулга, утга агуулгыг сайжруулах замаар үлдээж, Авто замын тухай хуульд Барилгын тухай хуулийг эшлэх.</p> | | |

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | Орон сууцны тухай 1999.04.22 |
|--|--|--|
| 10. | <p>46 дугаар зүйл. Барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигчийн үүрэг баримтлах зарчим 46.1.7.барилга байгууламжийн орчны тохижилтын засвар арчлалтыг тогтмол хийж, авто болон явган хүний зам, талбайн хөдөлгөөнийг хааж бусдад саад учруулахгүй байх;</p> | <p>14 дүгээр зүйл.Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн засвар, үйлчилгээ 14.5.Орон сууцны орчны зам, талбайн хөдөлгөөнийг хааж бусдад саад учруулахыг хориглоно.</p> |
| <p>Дүгнэлт: Барилгын тухай хууль болон Орон сууцны тухай хуульд орон сууцны орчны зам, талбайн хөдөлгөөнийг хааж бусдад саад учруулахгүй байх талаар агуулгын хувьд давхардуулан зохицуулсан байна.</p> | | |

Санал: Орон сууцны тухай хуулийн 14.5-д Барилгын тухай хуулийн 46.1.7 дахь заалтыг эшлэх.

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 <i>/Шинэчилсэн найруулга/</i> | Орон сууцны тухай хууль 1999.04.22 |
|-----|---|--|
| 11. | <p>46 дугаар зүйл. Барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигчийн үүрэг 46.1.3. барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцийг арчлан хамгаалах, зориулалтыг өөрчлөхгүй байх;</p> <p><u>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</u> <u>4.1.1. “барилга байгууламж” гэж орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээг;</u> <i>/Энэ заалтад 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i></p> | <p>15 дугаар зүйл. Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн зориулалт, төлөвлөлтийг өөрчлөх. 15.1. Орон сууцны байшингийн үндсэн хийц, бүтээцийг анхны зураг төслөөс өөрчлөх, нэмэлт ачаалал өгч давхарлах, өргөтгөл хийхийг хориглоно. <i>/Энэ хэсгийг 2011 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</i></p> |

Дүгнэлт: Орон сууцны тухай хууль болон Барилгын тухай хуульд барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцийг анхны зураг төслөөс өөрчлөхгүй байх талаар агуулгын хувьд давхардуулан зохицуулсан байна. Барилгын тухай хуулийн 4.1.1-д “барилга байгууламж” гэж орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээг; гэж томъёолсон тул Орон сууцны тухай хуулийн 15.1-д давтан зохицуулах шаардлагагүй.

Санал: Орон сууцны тухай хуулийн 15.1 дэх хэсэгт Барилгын тухай хуулийн 46.1.3 дахь заалтыг эшлэх.

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 <i>/Шинэчилсэн найруулга/</i> | Орон сууцны тухай хууль 1999.04.22 |
|-----|--|---|
| 12. | <p>33 дугаар зүйл. Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 33.1.2. энэ хуулийн 5.1.1, 5.1.2-т заасан барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг батлах;</p> <p><u>5 дугаар зүйл. Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг</u> <u>5.1.1. барилгын норм, дүрэм;</u> <u>5.1.2. барилгын болон</u> <u>техникийн дүрэм, заавар, цомог, аргачлал;</u> <u>5.1.3. стандарт.</u></p> | <p>7 дугаар зүйл. Орон сууцны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 7.1.2. орон сууцны төлөвлөлт, ашиглалтын норм, дүрэм, журам батлах, стандарт хянах, мөрдүүлэх;</p> <p><i>/Энэ заалтад 2003 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хууль, 2011 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i></p> |

Дүгнэлт: Барилгын тухай хуулийн 4.1.1-д “барилга байгууламж” гэж орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээг; гэж томъёолсон. Орон сууцны тухай хууль болон Барилгын тухай хуульд барилга байгууламжийн норм, дүрэм, журам батлах эрхийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд хамааруулан зохицуулсан нь агуулгын хувьд давхардсан зохицуулалт байна.

Санал: Орон сууцны тухай хуулийн 7.1.2-д Барилгын тухай хуулийн 33.1.2 дахь заалтыг эшлэх.

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | Хөрөнгө оруулалтын тухай хууль 2017.05.11 /Шинэчилсэн найруулга/ |
|---|--|--|
| 13. | 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 4.1.22."барилгын хөрөнгө оруулагч" гэж барилга байгууламжийг барихад шаардагдах хөрөнгийг санхүүжүүлсэн иргэн, хуулийн этгээдийг; | 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 3.1.2."хөрөнгө оруулагч" гэж Монгол Улсад хөрөнгө оруулалт хийсэн гадаад, дотоодын хөрөнгө оруулагчийг; |
| Дүгнэлт: Барилгын тухай хуульд Хөрөнгө оруулалтын тухай хуульд тодорхойлсон "хөрөнгө оруулагч" этгээдийн нэр томъёоны тодорхойлолтыг давхардуулан тодорхойлсон байна. | | |
| Санал: Хөрөнгө оруулалтын тухай хууль нь хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулагчийн талаарх суурь зохицуулалтыг агуулсан хууль тул Барилгын тухай хуульд Хөрөнгө оруулалтын хуулийг эшэлж, зохицуулалтыг уялдуулах. | | |

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | Хот байгуулалтын тухай хууль 2008.05.29 /Шинэчилсэн найруулга/ |
|---|---|---|
| 14. | 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 4.1.33."инженерийн дэд бүтэц" гэж авто зам, төмөр зам, дүүжин зам, газрын доор, дээр байрлах замын байгууламж, бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтээц бүхий байгууламжийг; | 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 3.1.10."инженерийн дэд бүтэц" гэж эрчим хүч, цэвэр, бохир усны болон зам, замын байгууламж, тээвэр, харилцаа холбооны шугам сүлжээ, барилга байгууламжийг; |
| Дүгнэлт: Барилгын тухай хууль болон Хот байгуулалтын тухай хуульд "инженерийн дэд бүтэц" гэсэн ойлголтыг нэр томъёоны хувьд давхардуулан тодорхойлсон байна. | | |
| Санал: Хот байгуулалтын хууль нь барилга, хот байгуулалтын суурь зохицуулалтыг агуулсан хууль тул Хот байгуулалтын тухай хуульд инженерийн дэд бүтцийн тодорхойлолтыг бүх салбарт нийцсэн байдлаар сайжруулан томъёолж, Барилгын тухай хуульд Хот байгуулалтын тухай хуулийг эшэлж, зохицуулалтыг уялдуулах. | | |

3.2. ЗӨРЧИЛ

7.2.1.тухайн зохицуулалт нь хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | Орон сууцны тухай хууль 1999.04.22 |
|----|--|--|
| 1. | 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: | 3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо 3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: |

| | |
|---|--|
| <p>4.1.1.“барилга байгууламж” гэж орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээг;</p> <p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь барилгын үйл ажиллагаа эрхлэх, барилгын материал үйлдвэрлэх, барилгын ажил гүйцэтгэх, түүнд хяналт тавих, ашиглалтад оруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> | <p>3.1.1.”орон сууц” гэж хүн суурьшин амьдрах зориулалттай нийтийн болон амины орон сууцны байшин, сууц, гэрийг;</p> <p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь орон сууцны талаарх төрийн байгууллагуудын бүрэн эрхийг тогтоож, орон сууц төлөвлөх, орон сууц хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх нийтийн зориулалттай орон сууцны байшингийн зориулалтыг өөрчлөх болон орон сууц ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. <i>/Энэ хэсэгт 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/</i></p> |
| <p><u>Дүгнэлт:</u> Дээрх 2 хуулийн зорилгыг харахад орон сууцыг барихаас ашиглалтад өгөх хүртэл харилцааг барилгын тухай хуулиар ашиглалтад орсон орон сууцыг ашиглахтай холбоотой харилцааг Орон сууцны хуулиар зохицуулахаар харагдаж байна. Харин Барилгын тухай хуулийн 46 дугаар зүйл. Барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигчийн үүрэг гэсэн зүйлд барилга байгууламжийн ашиглалтын үеийн өмчлөгч эзэмшигчийн эрх үүргийг заасан нь оновчтой эсэхийг анхааран үзэх шаардлагатай байна. Түүнчлэн 46 дугаар зүйлд заасан үүргийг Орон сууцны тухай хуульд эшлэх шаардлагатай.</p> | |

7.2.5.хуульд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн болон бусад хуулийн нэр томъёотой зөрчилдөж байгаа эсэх;

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | Зөвшөөрлийн тухай хууль 2022.06.17 /Шинэчилсэн найруулга/ | | | | | | |
|--|---|--|------------------|---|--|---|--|--------------------------------------|
| 2. | <p>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>4.1.15.“барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл /цаашид “<u>барилгын ажлын зөвшөөрөл</u>” гэх/ гэж энэ хуульд заасны дагуу барилгын ажлыг гүйцэтгэхийг зөвшөөрч, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг;</p> <p>4.1.21.“<u>барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл</u>” гэж Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан барилгын чиглэлээр эрх бүхий байгууллагаас олгосон үйл ажиллагаа эрхлэх эрхийг; <i>/Энэ заалтад 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</i></p> <p>26 дугаар зүйл. <u>Барилгын ажлын зөвшөөрөл</u></p> <p>26.1.Энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах</p> | <p>2.1 дүгээр зүйл.Зөвшөөрлийн ангилал</p> <p>1.Зөвшөөрлийг түүний зорилго, олгох нөхцөл, үйл ажиллагааны онцлог, эрсдэлийн түвшнээс хамааруулан доор дурдсанаар ангилна: 1.1.тусгай зөвшөөрөл; 1.2.<u>энгийн зөвшөөрөл.</u></p> <p>8.2 дугаар зүйл.Энгийн зөвшөөрлийн жагсаалт</p> <p>3.Барилга, хот байгуулалтын чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг <u>энгийн зөвшөөрөлтэйгөөр</u> эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:</p> <table border="1" data-bbox="842 1680 1469 1989"> <thead> <tr> <th data-bbox="842 1680 1158 1783">Энгийн зөвшөөрөл</th> <th data-bbox="1158 1680 1469 1783">Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="842 1783 1158 1917">3.2.барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг хэвлэх</td> <td data-bbox="1158 1783 1469 1917">Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага</td> </tr> <tr> <td data-bbox="842 1917 1158 1989">3.3.барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх</td> <td data-bbox="1158 1917 1469 1989">Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга</td> </tr> </tbody> </table> | Энгийн зөвшөөрөл | Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд | 3.2.барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг хэвлэх | Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага | 3.3.барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх | Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга |
| Энгийн зөвшөөрөл | Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд | | | | | | | |
| 3.2.барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг хэвлэх | Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага | | | | | | | |
| 3.3.барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх | Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга | | | | | | | |

| | |
|--|--|
| <p>барилга байгууламжид дараахь төрлөөр барилгын ажлын зөвшөөрөл олгоно: 26.1.1.барилга байгууламжийг шинээр барих; 26.1.2.барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэн барих; 26.1.3.барилга байгууламжийг буулгах.</p> | |
| <p>Дүгнэлт: Барилгын тухай хуульд барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл болон барилгын ажлын зөвшөөрлийн талаар зохицуулсан байна. 2022 онд батлагдсан Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад зөвшөөрлийг дотор нь тусгай зөвшөөрөл болон энгийн зөвшөөрөл гэсэн ангилалтай байхаар заасан байна. Агуулгын хувьд Барилгын тухай хууль дахь “барилгын ажлын зөвшөөрөл” нь энгийн зөвшөөрөл гэж ойлгогдож буй боловч нэр томъёоны талаасаа “энгийн” гэсэн тодотгол үг байхгүй байгаа нь Зөвшөөрлийн тухай хууль батлагдахад Барилгын тухай хуульд нэр томъёоны уялдуулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулаагүй гэж дүгнэхээр байна.</p> <p>Санал: Барилгын тухай хуульд “барилгын ажлын зөвшөөрөл”-ийн талаарх зохицуулалтад Зөвшөөрлийн хуультай нийцүүлж “энгийн зөвшөөрөл” гэж тодотгож нэмэх нь зүйтэй.</p> | |

7.2.7. Хуульд заасан эшлэл алдаатай эсэх

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | Барилгын тухай хууль 2016.02.05 |
|---|--|------------------------------------|
| 3. | <p>48.7.Барилга байгууламжийг дараахь тохиолдолд ашиглалтад оруулахаас татгалзана: 48.7.1.энэ хуулийн 48.5-д заасан баримт бичгийг бүрдүүлээгүй; 48.7.2.захиалагч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч энэ хуулийн 47.2, 47.5-д заасан хяналт шалгалт хийхэд саад учруулсан, татгалзсан; 48.7.3.энэ хуулийн 26 дугаар зүйлд заасан зөвшөөрлийн нөхцөлүүдийг зөрчсөн.</p> | 47.5 – энэ хуулийн заалт байхгүй. |
| <p>Дүгнэлт: Барилгын тухай хуулийн 48.7-д барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах тохиолдлуудыг дурдсан байна. Хуулийн 48.7.2 дахь хэсэгт 47.2, 47.5-д заасан шаардлагыг хангаагүй байвал ашиглалтад оруулахгүй байхаар хуульчилсан байна. Гэвч Барилгын тухай хуулийн 47.5 гэсэн заалт байхгүй байна. Иймд хуульд заасан эшлэл алдаатай байна.</p> <p>Санал: Эшлэл авсан заалтыг засаж “47.5-д заасан” гэснийг “47.4-т заасан” гэж засах</p> | | |

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | Орон сууцны тухай 1999.04.22 |
|---|--|---------------------------------|
|---|--|---------------------------------|

| | |
|--|---|
| <p>4. 3 дугаар зүйл. Барилгын салбарт төрийн үйлчилгээ үзүүлэхэд баримтлах зарчим</p> <p>3.1.Барилгын салбарт төрийн үйлчилгээ үзүүлэхэд дараахь зарчмыг баримтална: 3.1.1.барилгын үйл ажиллагааны зохицуулалт, бүртгэл, зөвшөөрлийг олон нийтэд ил тод, нээлттэй, шуурхай зохион байгуулах; 3.1.2.барилгын үйл ажиллагаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдлыг хангах.</p> <p>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>4.1.25.“гадна тохижилтын ажил” гэж барилга байгууламжийн гаднах талбайн ногоон байгууламж, автозам, зогсоол, явган хүний зам, гарц, оршин суугчдын амрах болон хүүхдийн тоглоомын талбай, уран барилгын жижиг хэлбэр, гэрэлтүүлэг зэргийг барьж байгуулах үйл ажиллагааг;</p> | <p>3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо</p> <p>3.1.5.“орон сууцны байшингийн орчны тохижилт” гэж Барилгын тухай хуулийн 3.1.11-д заасан барилгын орчны тохижилтыг;</p> |
| <p>Дүгнэлт: Орон сууцны тухай хуулийн 3.1.5-д 2008 онд батлагдсан Барилгын тухай хуулийн 3.1.11 дэх заалтыг эшлэсэн. 2016 онд батлагдсан Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар 3 дугаар зүйл нь 3.1.1, 3.1.2 гэсэн 2 заалттай болсон. Ингэснээр Орон сууцны тухай хууль дахь эшлэл алдаатай болсон байна.</p> <p>Санал: Орон сууцны тухай хуулийн 3.1.5-д Барилгын тухай хуулийн 4.1.25 дахь заалтыг эшлэх.</p> | |

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль 2011.06.16 |
|---|---|--|
| 5. | <p>7 дугаар зүйл. Нийтийн болон гуравдагч этгээдийн эрх, ашиг сонирхол</p> <p>7.4.Барилга байгууламжийн зураг төсөл, байр зүйн дэвсгэр зураг зэрэг мэдээлэл нийтэд нээлттэй, ил тод байна. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 18.1-д заасан мэдээлэл үүнд хамаарахгүй.</p> | Хүчингүй болсон хууль |
| <p>Дүгнэлт: Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль нь 2021 онд хүчингүй болсон бөгөөд Барилгын тухай хуулийн 7.4 дэх хэсэгт хүчингүй болсон хуулийн нэрийг дурдсан байна. Ингэснээр Барилгын тухай хууль дахь эшлэл алдаатай болсон байна.</p> <p>Санал: Барилгын тухай хуульд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн холбогдох заалтаар өөрчилж, засах.</p> | | |

7.2.8.тухайн хуульд бусад хуулиас авсан эшлэлийн дугаар нь нөгөө хуульд байгаа зохицуулалттай нийцэж байгаа эсэх;

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | Газрын тухай хууль 2002.06.07 |
|--|--|---|
| 6. | <p>8 дугаар зүйл. Барилгын салбарын даатгал</p> <p>8.1.Барилгын үйл ажиллагаанд оролцогч учирч болзошгүй эрсдлийг даатгуулж болно.</p> <p>8.2.Барилгын үйл ажиллагаанд оролцогчийн буруутай үйлдэл, эс үйлдэхгүйгээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирч болзошгүй хохирлыг даатгуулна. Даатгалыг захиалагч, гүйцэтгэгч урьдчилан тохиролцон барилгын ажил гүйцэтгэх гэрээнд тусгана.</p> <p>8.3.Энэ хуулийн 44.3.2, 44.3.3-т заасан мэргэшлийн зэрэгтэй мэргэжилтэн мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулна.</p> <p>8.4.Барилгын ажлын гүйцэтгэгч тухайн барилга байгууламж дээр ажиллах ажилтнуудыг амь насны даатгалд хамруулна.</p> | <p>44¹дүгээр зүйл. Сууц өмчлөгчдийн холбоонд орчны газрыг ашиглуулах</p> <p>44¹.7.Сууц өмчлөгчдийн холбоонд ашиглуулах орчны газрын хэмжээг тогтоохдоо Барилгын тухай хуулийн 8 дугаар зүйл болон барилгын холбогдох норм, дүрмийг баримтална.</p> |
| <p>Дүгнэлт: Барилгын тухай хуулийн 8 дугаар зүйлд Барилгын салбарын даатгалын талаарх зохицуулалт байгаа бөгөөд Газрын тухай хуулийн 44¹.7-д авсан эшлэлийн дугаартай нийцэхгүй байна.</p> | | |
| <p>Санал: Барилгын тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг эшлэх.</p> | | |

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль 2011.10.06 |
|--|--|--|
| 7. | <p>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> | <p>5 дугаар зүйл. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх</p> <p>5.1.3.хот, суурины ус хангамж, ариутгах татуургын төрийн өмчийн барилга байгууламжийн захиалагчийн үүргийг Барилгын тухай хууль [4] болон холбогдох бусад хууль тогтоомжид зааснаар хэрэгжүүлэх;</p> |
| <p>Дүгнэлт: Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйл нь хуулийн нэр томъёоны тодорхойлолт. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 5 дугаар зүйлд Барилгын тухай хуулиас эшлэсэн нь холбоогүй байна.</p> | | |
| <p>Санал: Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийг эшлэх.</p> | | |

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай 2002.06.27 |
|---|--|---|
|---|--|---|

| | | |
|---|--|---|
| 8. | <p>17 дугаар зүйл. Барилгын ажил гүйцэтгэх газарт сервитут тогтоох</p> <p>17.2.Зайлшгүй шаардлагатай тохиолдолд дараахь барилгын ажилд зориулан зэргэлдээ орших газарт, эсхүл үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч, эзэмшигчийн газар болон үл хөдлөх эд хөрөнгөд сервитут тогтооно:</p> <p>17.2.1.барилга байгууламж барих, шинэчлэн барих, засварлах;</p> <p>17.2.2.шугам сүлжээ, дэд бүтцийн байгууламж барих, шинэчлэн барих;</p> <p>17.2.3.тухайн газар нутагт хөрсний инженерийн хайгуулын судалгаа гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх, хамгаалалтад авах;</p> <p>17.2.4.барилга байгууламжид түр болон байнгын зориулалттай нэвтрэх орц барьж байгуулах.</p> <p>17.3.Энэ хуулийн 17.2-т заасны дагуу тусгай хэрэгцээний газар, нийтийн эзэмшлийн газар, талбайг барилгын үйл ажиллагаанд түр хугацаагаар ашиглахад аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр сервитут тогтоож болно.</p> | <p>33 дугаар зүйл.Газар өмчлөгч иргэний эрхийг хязгаарлах эрх /сервитут/</p> <p>33.1.Сум, дүүргийн Засаг дарга улсын болон тухайн нутаг дэвсгэрийн хүн амын нийтлэг ашиг сонирхлыг хангах зайлшгүй шаардлагатай тохиолдолд иргэнд өмчлүүлсэн газарт дор дурдсан нийтийн сервитут тогтоож болно:</p> <p>33.1.1.уг газраар дамжин өнгөрөх;</p> <p>33.1.2.уг газарт газрын заагийн болон геодезийн байнгын цэг, тэмдэгт тавих;</p> <p>33.1.3.намагжилтыг багасгах ажил гүйцэтгэх;</p> <p>33.1.4.газар зохион байгуулалтын бусад арга хэмжээ хэрэгжүүлэх.</p> |
| <p>Дүгнэлт: Барилгын тухай хуульд иргэний өмчийн газарт барилгын ажил гүйцэтгэх зарим тохиолдолд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр сервитут тогтоохоор зохицуулсан бол Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд сум, дүүргийн засаг дарга сервитут тогтоож болохоор зохицуулсан байна.</p> | | |
| <p>Санал:Барилгын тухай хуулийн 17.3-т Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу “аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн” гэснийг “сум, дүүргийн засаг дарга” гэж өөрчлөх</p> | | |

| № | <p>Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/</p> | <p>Эрүүл ахуйн тухай хууль 2016.02.04</p> |
|----|---|---|
| 9. | <p>13 дугаар зүйл. Барилгын материал, бүтээгдэхүүнд тавих шаардлага.</p> <p>13.1.Барилга байгууламжид ашиглах барилгын материал, бүтээгдэхүүн дараахь шаардлагыг хангасан байна:</p> <p>13.1.1.барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг, зураг төслийн шаардлагыг бүрэн хангасан байх;</p> <p>13.1.2.хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй байх;</p> <p>13.1.3.чанарыг баталгаажуулсан гарал үүслийн гэрчилгээ, лабораторийн батламжтай байх;</p> | <p>5 дугаар зүйл. Хот төлөвлөлт, барилга байгууламжид тавих эрүүл ахуйн шаардлага</p> <p>5.4.Барилгын материал нь эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт болон Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байна.</p> |

| | |
|--|--|
| <p>13.1.4.чанарын шаардлага хангасан зориулалтын сав, баглаа, боодол, хаяг, шошготой байх.</p> <p>13.2.Барилгын материал, бүтээгдэхүүнийг барилга байгууламжийн зориулалт, төлөвлөлтийн дагуу сонгож зураг төсөлд тусгана.</p> <p>13.3.Барилга байгууламжийн зураг төсөлд барилгын материал, бүтээгдэхүүний стандартын шаардлагын тухай мэдээллийг тусгана.</p> <p>13.4.Барилгын материал, бүтээгдэхүүнийг барилгын ажлын явцад захиалагч, гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн зураг төсөл зохиогчийн шийдвэрээр өөрчилнө.</p> <p>13.5.Барилгын материалын үйлдвэрлэл, олборлолт болон барилгын материал, бүтээгдэхүүнд тавих нарийвчилсан шаардлагыг барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгээр зохицуулна.</p> | |
| <p>Дүгнэлт: Эрүүл ахуйн тухай хуулийн 5.4 дэх хэсэгт “Барилгын материалын эрүүл ахуйн үзүүлэлтийг Барилгын тухай 11-р зүйлд заасан шаардлагыг хангасан байна гэж зохицуулсан боловч Барилгын тухай хуулийн 13-р зүйлд материалын шаардлагыг тусган оруулсан байна. Иймд Эрүүл ахуйн тухай хуульд буруу заалт эшлэсэн. Мөн Барилгын тухай хуулийн зохицуулалттай нийцэхгүй байна.</p> <p>Санал: Эрүүл ахуйн тухай хуулийн 5.4 дэх хэсэгт эшлэсэн заалтыг Барилгын тухай хуулийн 13 дугаар зүйл гэж өөрчлөх.</p> | |

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | Эрүүл ахуйн тухай хууль 2016.02.04 |
|---|--|--|
| 10. | Зохицуулалт байхгүй. | <p>5 дугаар зүйл. Хот төлөвлөлт, барилга байгууламжид тавих эрүүл ахуйн шаардлага</p> <p>5.7.Орон сууц, албан байгууллага, үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллага нь барилгын орчны тохижилтыг Барилгын тухай хуулийн 3.1.11-д болон Хот байгуулалтын тухай хуулийн 12.6.3-т заасны дагуу төлөвлөж гүйцэтгэнэ</p> |
| <p>Дүгнэлт: Эрүүл ахуйн тухай хуулийн 5.7 дахь хэсэгт Барилгын тухай хуулийн 3.1.11-д заасныг эшлэсэн боловч Барилгын тухай хуульд энэ заалт байхгүй байна.</p> <p>Санал: Барилгын орчны тохижилт, гадна тохижилт зэрэг асуудлууд Барилгын тухай хуульд хэд хэдэн зүйл, хэсэгт зохицуулагдаж байх тул “Барилгын тухай хуульд заасны дагуу” гэж өөрчлөх.</p> | | |

7.2.13.Хуулийн зүйл, заалт нь тухайн хууль болон өөр хуулийн заалттай зөрчилдөж буй эсэх.

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | Зөвшөөрлийн тухай хууль 2022.06.17 /Шинэчилсэн найруулга/ | | | | | | | | |
|--|--|---|------------------|---|--|---|------------------|---|--|--------------------------------------|
| 11. | <p>18 дугаар зүйл. Барилгын үйл ажиллагаа эрхлэх 18.1.Барилгын үйл ажиллагааг энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу тусгай зөвшөөрөл, барилгын ажлын зөвшөөрөл, бүртгэлийн үндсэн дээр эрхэлнэ. 18.2.Энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах <u>барилга байгууламжийн барилгын ажлыг⁸ барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд эрхэлнэ.</u></p> <p>26 дугаар зүйл. Барилгын ажлын зөвшөөрөл⁹ 26.1.Энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжид дараахь төрлөөр барилгын ажлын зөвшөөрөл олгоно: 26.1.1.барилга байгууламжийг шинээр барих; 26.1.2.барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэн барих; 26.1.3.барилга байгууламжийг буулгах.</p> <p>27 дугаар зүйл. Барилгын ажлын зөвшөөрөл олгох үйл ажиллагаа <i>/Энэ зүйлийг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</i> 27.1.Барилгын ажлын зөвшөөрлийг дараах эрх бүхий этгээд олгоно: <i>/Энэ хэсгийг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</i> 27.1.1.энэ хуулийн 32.1.5-д заасан зөвшөөрлийг Засгийн газар; <i>/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</i> <u>27.1.2.энэ хуулийн 10.1.5¹⁰, 20.2-т заасан зөвшөөрлийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;</u> <i>/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</i> 27.1.3.энэ хуулийн 27.1.1, 27.1.2-т зааснаас <u>бусад зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга.</u></p> | <p>2.1 дүгээр зүйл.Зөвшөөрлийн ангилал 1.Зөвшөөрлийг түүний зорилго, олгох нөхцөл, үйл ажиллагааны онцлог, эрсдэлийн түвшнээс хамааруулан доор дурдсанаар ангилна: 1.1.тусгай зөвшөөрөл; 1.2.энгийн зөвшөөрөл.</p> <p>8.1 дүгээр зүйл.Тусгай зөвшөөрлийн жагсаалт 3.Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:</p> <table border="1" data-bbox="949 795 1460 1153"> <thead> <tr> <th>Тусгай зөвшөөрөл</th> <th>Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>3.2.бага, дунд, өндөр, онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн барилгын ажил эрхлэх</td> <td>Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага</td> </tr> </tbody> </table> <p>8.2 дугаар зүйл.Энгийн зөвшөөрлийн жагсаалт 3.Барилга, хот байгуулалтын чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлтэйгээр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:</p> <table border="1" data-bbox="949 1444 1460 1668"> <thead> <tr> <th>Энгийн зөвшөөрөл</th> <th>Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>3.3.барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх</td> <td>Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга</td> </tr> </tbody> </table> | Тусгай зөвшөөрөл | Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд | 3.2.бага, дунд, өндөр, онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн барилгын ажил эрхлэх | Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага | Энгийн зөвшөөрөл | Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд | 3.3.барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх | Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга |
| Тусгай зөвшөөрөл | Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд | | | | | | | | | |
| 3.2.бага, дунд, өндөр, онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн барилгын ажил эрхлэх | Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага | | | | | | | | | |
| Энгийн зөвшөөрөл | Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд | | | | | | | | | |
| 3.3.барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх | Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга | | | | | | | | | |

⁸ 4.1.11."барилгын ажил" гэж бүх төрлийн барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэх талбайг бэлтгэх, бүрдэл хэсгийг угсрах, шинэчлэн барих, буулгах, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулах үйл ажиллагааг;

⁹ 4.1.15."барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл /цаашид "барилгын ажлын зөвшөөрөл" гэх/ гэж энэ хуульд заасны дагуу барилгын ажлыг гүйцэтгэхийг зөвшөөрч, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг;

¹⁰ 10.1.5.онцгой төвөгшилтэй барилга байгууламж.

| | | |
|--|---|--|
| | /Энэ хэсгийг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./ | |
|--|---|--|

Дүгнэлт: Барилгын тухай хууль болон Зөвшөөрлийн тухай хууль дахь барилгын зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт, заалтууд нь зарим талаар зөрчилтэй болсон байна. Барилгын тухай хуульд барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл 18 дугаар зүйл, барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл буюу барилгын ажлын зөвшөөрөл гэсэн 2 ялгамжтай зөвшөөрлийн талаар хуульчилсан. 2021 онд батлагдсан Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгай болон энгийн зөвшөөрлийг ялгаж хуульчилсан. Барилгын тухай хуульд зөвшөөрлийг тусгай зөвшөөрөл бол үгээрээ орсон, харин бусад зөвшөөрөлд “энгийн” гэдэг тодотгол хэрэглээгүй нь тухайн хуулийн бичвэр, хэрэглээ, тайлбар, ойлгомжтой байдалд тодорхой хэмжээнд нөлөөлж байна. Зөвшөөрлийн хуулийг батлах үед БТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулахдаа барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлөөс бусад зөвшөөрөлд “энгийн зөвшөөрөл” гэсэн тодотголыг оруулах нь зүйтэй байсан. Түүнчлэн, БТХ-ийн 27.1.2-т тус хуулийн 10.1.5-д заасан барилга байгууламжийн зөвшөөрлийг БХБЯ олгохоор заасан бол Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 3.3-т барилгын төрлийг заалгүйгээр барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх энгийн зөвшөөрлийг тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга олгохоор заасан нь зөрчилтэй уншигдаж байна.

Санал: Барилгын тухай хуульд барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл болон барилгын ажлын зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Зөвшөөрлийн хуультай нийцүүлэн тодорхой, ойлгомжтой болгож хуульчлах.

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017.06.09 /Шинэчилсэн найруулга/ |
|--|---|--|
| 12. | <p>26 дугаар зүйл. Барилгын ажлын зөвшөөрөл</p> <p>26.1.Энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжид дараахь төрлөөр барилгын ажлын зөвшөөрөл олгоно:</p> <p>26.1.1.барилга байгууламжийг шинээр барих;</p> <p>26.1.2.барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэн барих;</p> <p>26.1.3.барилга байгууламжийг буулгах.</p> | <p>100 дугаар зүйл.Орон байр, барилгаас нүүлгэн гаргах, байр, агуулах сав, газар чөлөөлөх, барилга байгууламжийг нураах тухай шийдвэрийг гүйцэтгэх</p> <p>100.3.Гүйцэтгэх баримт бичигт заасан барилга байгууламжийг нураах, буулгах болон барилгын үлдэгдэл хог хаягдлаас газрыг цэвэрлэх ажиллагаа явуулснаар барилга байгууламжийг албадан нураах тухай гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг гүйцэтгэсэнд тооцно.</p> |
| <p>Дүгнэлт: Барилгын тухай хуульд “барилга байгууламжийг буулгах” талаар тусгасан хэдий ч энэ талаарх нэр томъёоны тодорхойлолт болон дэлгэрэнгүй зохицуулалт байхгүй байна. Нөгөө талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 100.3 дахь хэсэгт “... барилга байгууламжийг нураах” гэсэн томъёоллыг тусгасан нь Барилгын тухай хуулийн зохицуулалттай зөрчилдөж байна.</p> <p>Санал: Барилгын тухай хуульд “барилга байгууламжийг буулгах” талаар нэр томъёоны тодорхойлолтыг тусгаж, дэлгэрэнгүй зохицуулалтыг оруулахаас гадна Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд Барилгын хуультай нийцүүлсэн өөрчлөлтийг оруулах шаардлагатай.</p> | | |

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | Орон сууцны тухай хууль 1999.04.22 | СӨХЭЗБНЗОСБДӨЭХТ 2003.06.18 |
|---|--|---------------------------------------|--------------------------------|
|---|--|---------------------------------------|--------------------------------|

| | | | |
|--|--|--|---|
| 13. | 46 дугаар зүйл.Барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигчийн үүрэг 46.1.3.барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцийг арчлан хамгаалах, зориулалтыг өөрчлөхгүй байх; | 15 дугаар зүйл.Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн зориулалт, төлөвлөлтийг өөрчлөх 15.1.Орон сууцны байшингийн үндсэн хийц, бүтээцийг анхны зураг төслөөс өөрчлөх, нэмэлт ачаалал өгч давхарлах, өргөтгөл хийхийг хориглоно. | 7 дугаар зүйл.Холбооны эрх барих дээд байгууллага 7.1.Холбооны эрх барих дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал байна. 7.2.Дараахь асуудлыг зөвхөн бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ: <u>7.2.9.сууц өмчлөгч сууцныхаа зориулалт, төлөвлөлтийг өөрчлөх зорилгоор орчны газарт барилга барих;</u> 13 дугаар зүйл. Сууц өмчлөгчийн эрх, үүрэг 13.2.7.сууцныхаа зориулалт, төлөвлөлт, үндсэн бүтээц, хийц, инженерийн шугам сүлжээг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөрчлөхгүй байх. |
| <p>Дүгнэлт: Орон сууцны тухай хуулийн 15.1, Барилгын тухай хуулийн 46.1.3-д орон сууцны байшингийн үндсэн хийц, бүтээцийг анхны зураг төслөөс өөрчлөх, нэмэлт ачаалал өгч давхарлах, өргөтгөл хийхийг хориглохоор заасан. СӨХЭЗБНЗОСБДӨЭХТухай хуулийн 7.2.9-д бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэсэн бол, 13.2.7-д эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй бол сууц өмчлөгч сууцныхаа зориулалт, төлөвлөлтийг өөрчлөх зорилгоор орчны газарт барилга барьж болохоор зохицуулсан нь Орон сууцны тухай хууль болон Барилгын тухай хуулийн холбогдох заалтуудтай зөрчилдөж байна.</p> | | | |
| <p>Санал: СӨХЭЗБНЗОСБДӨЭХТухай хуулийн 7.2.9, 13.2.7 дахь заалтыг тус тус хүчингүй болгох.</p> | | | |

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | Орон сууцны тухай хууль 1999.04.22 | Зөрчлийн тухай хууль 2017.05.11 |
|--|--|--|--|
| 14. | 46 дугаар зүйл.Барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигчийн үүрэг 46.1.3.барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцийг арчлан хамгаалах, зориулалтыг өөрчлөхгүй байх; | 15 дугаар зүйл.Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн зориулалт, төлөвлөлтийг өөрчлөх 15.1.Орон сууцны байшингийн үндсэн хийц, бүтээцийг анхны зураг төслөөс өөрчлөх, нэмэлт ачаалал өгч давхарлах, өргөтгөл хийхийг хориглоно. | 12.4 дүгээр зүйл.Орон сууцны тухай хууль зөрчих 1.Орон сууцны төлөвлөлт, барилгын үндсэн бүтэц, хийц, инженерийн шугам сүлжээг зөвшөөрөлгүйгээр анхны зураг төслөөс өөрчилсөн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. |
| <p>Дүгнэлт: Орон сууцны тухай хуулийн 15.1, Барилгын тухай хуулийн 46.1.3-д орон сууцны байшингийн үндсэн хийц, бүтээцийг анхны зураг төслөөс өөрчлөх, нэмэлт ачаалал өгч давхарлах, өргөтгөл хийхийг хориглохоор заасан.</p> | | | |
| <p>Санал: Зөрчлийн тухай хуулийн 12.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “зөвшөөрөлгүйгээр” гэснийг хасах.</p> | | | |

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | Хот байгуулалтын тухай хууль 2008.05.29 /Шинэчилсэн найруулга/ | Газрын тухай хууль 2002.06.07 /Шинэчилсэн найруулга/ |
|-----|---|---|---|
| 15. | <p>14 дүгээр зүйл. Барилга байгууламжид тавих шаардлага</p> <p>14.2.Барилга байгууламжийн гадна тохижилтын талбай, ногоон байгууламж хот төлөвлөлтийн норм, нормативын баримт бичигт заасан хэмжээнээс багагүй байна.</p> | <p>12 дугаар зүйл. Хот байгуулалтын баримт бичигт тавигдах шаардлага</p> <p>12.6.3.Төлөвлөгөөнд хамааруулсан нийт газар нутгийн 30-аас доошгүй хувь нь цэцэрлэг, ногоон байгууламж, автомашины зогсоол байх.</p> <p>12.8.Барилга байгууламжийн зураг төсөл нь хот, тосгоны батлагдсан ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний шийдлүүд, олгогдсон газрын хэмжээ, зориулалттай уялдсан байх бөгөөд барилгажих талбай нь тухайн газрын 70 хувиас илүүгүй байна.</p> | <p>56 дугаар зүйл.Хот, тосгон, бусад суурины газрыг зохистой ашиглах, хамгаалах</p> <p>56.6.Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана гэжээ.</p> |

Дүгнэлт: Ногоон байгууламж цэцэрлэгжүүлэлтийн асуудал нь Хот байгуулалтын тухай хуулиар зохицуулагдаж байгаа ч түүнийг байгуулах, ашиглалтыг бий болгох үйл явц нь Барилгын тухай хууль, Газрын тухай хуулиар зохицуулж байна. Дээрх хуулиудын зүйл, заалтыг харахад ногоон байгууламжтай холбогдолтой зохицуулалтын асуудлыг салбар бүрийн онцлогоос хамаарч ногоон байгууламж төлөвлөн, байгуулах тоо хэмжээг өөр, өөрөөр тогтоосон нь уялдаа холбоогүй, харилцан зөрчилтэй болсон байна.

Санал: Барилгын тухай хууль болон холбогдох бусад хуульд ногоон байгууламжийн талаар харилцан уялдаатай, хэрэгжихүйц зохицуулалтыг тусгаж өгөх шаардлагатай.

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН НОРМ, НОРМАТИВЫН БАРИМТ БИЧГИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦОО |
|-----|---|--|
| 16. | <p>5 дугаар зүйл. Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг</p> <p>5.1.Барилгын үйл ажиллагааг доор дурдсан норм, нормативын баримт бичгээр зохицуулна:</p> <p>5.1.1.барилгын норм, дүрэм;</p> <p>5.1.2.барилгын болон техникийн дүрэм, заавар, цомог, аргачлал;</p> <p>5.1.3.стандарт.</p> | <p>Дөрөв. Тогтолцооны бүтэц</p> <p>4.2.Дараахь баримт бичгийг заавал мөрдөнө:</p> <p>4.2.1. техникийн зохицуулалт;</p> <p>4.2.2. барилгын норм ба дүрэм.</p> |

Дүгнэлт: Хуулийн 5.1.1 дэх заалт, барилгын дүрмийн 4.2 дахь зохицуулалт хоорондоо нийцэхгүй байна.

Санал: Норм, дүрмийг хуульд нийцүүлэх, эсвэл хуулийн 5.1.1 дэх заалтыг “5.1.1.Техникийн зохицуулалт, барилгын норм ба дүрэм” гэж өөрчлөх.

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН НОРМ, НОРМАТИВЫН БАРИМТ БИЧГИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦОО |
|-----|---|--|
| 17. | 5 дугаар зүйл. Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг 5.1.Барилгын үйл ажиллагааг доор дурдсан норм, нормативын баримт бичгээр зохицуулна: 5.1.1.барилгын норм, дүрэм; 5.1.2.барилгын болон техникийн дүрэм, заавар, цомог, аргачлал; 5.1.3.стандарт. 5.2.Барилгын үйл ажиллагаанд энэ хуулийн 5.1.1-д заасан барилгын норм, дүрмийг заавал, 5.1.2-т заасан баримт бичгийг сонгож мөрдөнө. | Дөрөв. Тогтолцооны бүтэц 4.3.Дараахь баримт бичгийг сонгон мөрдөнө: 4.3.5.стандарт. |

Дүгнэлт: Хуулийн 5.2 дахь заалт, дүрмийн 4.3.5 дахь зохицуулалт хоорондоо нийцэхгүй байна.

Санал: Барилгын норм, дүрмийг хуульд нийцүүлэх, эсвэл хуулийн заалтыг доор дурдсанаар өөрчлөх.

5.2.Барилгын үйл ажиллагаанд энэ хуулийн 5.1.1-д заасан барилгын норм, дүрмийг заавал, 5.1.2, 5.1.3-т заасан баримт бичгийг сонгож мөрдөнө.

3.3. ХИЙДЭЛ

7.3.2.тухайн хуульд тодорхой харилцааны нарийвчилсан зохицуулалтыг батлах эрхийг төрийн бусад байгууллагад шилжүүлсэн бол уг нарийвчилсан зохицуулалт батлагдсан эсэх;

Тайлбар:

Хийдэл хэсэгт Барилгын тухай хуульд дурдсан бүх дүрэм, журам, норм нормативын баримт бичгийг шалгасан бөгөөд холбогдох байгууллагуудаас бүх баримт бичгийг баталсан байна.

7.3.4.тодорхой эрх, үүргийг хэрэгжүүлэх этгээд нь тодорхой эсэх;

| № | Барилгын тухай 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ |
|----|---|
| 1. | 34 дүгээр зүйл. Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг |

| | |
|--|--|
| | <p>34.1.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>34.1.1.барилгын тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангах;</p> <p>34.1.2.барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг, стандарт боловсруулах ажлыг зохион байгуулах;</p> <p>34.1.3.барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах;</p> <p>34.1.4.барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулах;</p> <p>34.1.5.барилгын салбарын шинжлэх ухаан, техник технологийн бодлогыг хэрэгжүүлэх;</p> <p>34.1.6.барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг сурталчлах, нэвтрүүлэх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;</p> <p>34.1.7.барилгын салбарын ажилтан, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл хөтлөх, шинэчлэх, мэдээллийг мэдээллийн санд байршуулах, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;</p> <p>34.1.8.барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ, үнийн индексийг боловсруулах;</p> <p>34.1.9.улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах барилгын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгогчийг төлөөлөн оролцох;</p> <p>34.1.10.барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээдийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, экспертийн эрх олгох;</p> <p>34.1.11.зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл хөтлөх;</p> <p>34.1.12.барилга байгууламжийн норм, нормативын сан бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг зохион байгуулах;</p> <p>34.1.13.архитектор, инженерийн мэргэжлийн зөвлөл байгуулан, үйл ажиллагааг нь зохион байгуулах;</p> <p>34.1.14.барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг нэг цэгийн үйлчилгээгээр зохион байгуулах;</p> <p>34.1.15.барилгын материалын үйлдвэрлэлийн технологийн зааврыг хянаж, баталгаажуулах ажлыг зохион байгуулах;</p> <p>34.1.16.хууль тогтоомжид заасан бусад эрх.</p> <p>34.2.Энэ хуулийн 34.1.2, 34.1.3, 34.1.4, 34.1.6, 34.1.7, 34.1.8, 34.1.9, 34.1.10, 34.1.11, 34.1.13, 34.1.14, 34.1.15-д заасан чиг үүргийг эрх бүхий байгууллагын шийдвэрийн үндсэн дээр төрийн бус, мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.</p> |
| | <p>Дүгнэлт: Барилгын тухай хуулийн 34 дүгээр зүйлд барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын 16 чиг үүргийг тусгасан байх бөгөөд 2023 оны 9 сарын байдлаар барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байхгүй байна. Цаашдаа барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байгуулж, дээрх чиг үүргийн хэрэгжилтийг хангах нь зүйтэй юм.</p> |

7.3.6.хуульд заасан хориглосон зохицуулалт нь түүнийг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх;

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | Зөрчлийн тухай хууль 2017.05.11 /Шинэчилсэн найруулга/ |
|----|--|--|
| 2. | 37.5.Газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл олгоогүй, зураг төсөл нь боловсруулагдаж дуусаагүй орон сууцны барилгад иргэдээс хөрөнгө төвлөрүүлэхийг хориглоно. | Зохицуулалт байхгүй. |

Дүгнэлт: Барилгын тухай хуулийн 37.5 дахь хэсэгт заасан хориглосон зохицуулалтад хамаарах уг зохицуулалтыг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагын талаар Зөрчлийн тухай хуульд тодорхой зохицуулалт байхгүй байна.

Санал: Зөрчлийн тухай хуульд Барилгын тухай хуулийн 37.5 дахь хэсгийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаарх нэмэлт зохицуулалтыг тодорхой тусгаж өгөх.

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | Зөрчлийн тухай хууль 2017.05.11 /Шинэчилсэн найруулга/ |
|----|--|--|
| 3. | 14 дүгээр зүйл. Барилга байгууламжид тавих шаардлага 14.4.Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсон тохиолдолд гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, захиалагч болон ашиглагч тухайн барилга байгууламжид хамтарсан үзлэг хийж, зөрчлийг арилгах талаар тэмдэглэл үйлдэнэ. | Зохицуулалт байхгүй. |

Дүгнэлт: Барилгын тухай хуулийн 14.4 дэх хэсэгт заасан тэмдэглэл үйлдээгүй тохиолдолд авах арга хэмжээ, ийнхүү тэмдэглэл үйлдээгүйд тооцох хариуцлагын заалт, тодорхой зохицуулалт Барилгын хуульд ч, Зөрчлийн хуульд ч байхгүй байна.

Санал: Зөрчлийн тухай хууль болон БТХ-д Барилгын тухай хуулийн 14.4 дэх хэсгийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, авах арга хэмжээний талаарх нэмэлт зохицуулалтыг тодорхой тусгаж өгөх.

7.3.8.хуульд байх шаардлагатай зохицуулалт тусгагдсан эсэх;

| № | Барилгын тухай 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ |
|---|---|
| 4. | 47 дугаар зүйл. Барилга байгууламжийн техникийн улсын хяналт Хуулийн 47 дугаар зүйлд барилга байгууламжийн техникийн улсын хяналтын талаар зохицуулсан. Техникийн хяналтын дүгнэлт гарсны дараа улсын комиссын хүлээн авснаар барилга байгууламж ашиглалтад ордог. |
| Санал, дүгнэлт: Улсын комисс шаардлага хангаагүй барилга байгууламжийг хүлээн авч акт гаргасан тохиолдолд зохицуулах харилцааг Барилгын тухай хуульд тусгах. | |

| № | Барилгын тухай 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ |
|----|--|
| 5. | 20 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох 20.12.1.энэ хуулийн 10.1.5, 20.2-т заасан барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах даалгаврыг хянан баталгаажуулсан холбогдох мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт; 25.7.Энэ хуулийн 25.6-д заасан магадлалын дүгнэлттэй холбоотой маргаантай асуудлыг холбогдох мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлүүлж болно. 33.1.12.архитектор, инженерийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам батлах; |

| | |
|---|--|
| | 34.1.13.архитектор, инженерийн мэргэжлийн зөвлөл байгуулан, үйл ажиллагааг нь зохион байгуулах; 37.9.Доорхи барилга байгууламжийн зураг төслийн даалгавар, норм, нормативын баримт бичгийн техникийн даалгаврыг холбогдох мэргэжлийн зөвлөлөөр хянуулсан байна: |
| Дүгнэлт: Барилгын тухай хуульд “мэргэжлийн зөвлөл” гэсэн нэр томъёо хэд хэд давтагдаж зохицуулагдсан байх бөгөөд хуулийн нэр томъёоны хэсэгт “мэргэжлийн зөвлөл” гэсэн томъёолол байхгүй. | |
| Санал: Мэргэжлийн зөвлөлийн талаар нэр томъёоны тодорхойлолтод оруулах, мөн “холбогдох мэргэжлийн зөвлөл”, “архитектор, инженерийн орон тооны бус мэргэжлийн зөвлөл”, “архитектор, инженерийн мэргэжлийн зөвлөл” гэж хэд хэдэн янзаар бичигдсэн байгааг хуульд тодорхой, ойлгомжтой зохицуулалтыг тусгаж өгөх. | |

| | |
|---|--|
| № | Барилгын тухай 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ |
| 6. | 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 4.1.2."барилга байгууламжийг ашиглалтад оруулсан гэрчилгээ" гэж барилга байгууламжийг ашиглалтад оруулсныг баталгаажуулан эрх бүхий байгууллагаас олгох баримт бичгийг; |
| Дүгнэлт: Барилгын тухай хуульд "барилга байгууламжийг ашиглалтад оруулсан гэрчилгээ" гэсэн нэр томъёотой холбоотой үр дагаврын зохицуулалт байхгүй байна. | |
| Санал: Барилгын тухай хуульд "барилга байгууламжийг ашиглалтад оруулсан гэрчилгээ" гэсэн нэр томъёотой холбоотой үр дагаврын зохицуулалтыг тодорхой тусгаж өгөх. | |

| | |
|---|--|
| № | Барилгын тухай 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ |
| 7. | 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 4.1.22."барилгын хөрөнгө оруулагч" гэж барилга байгууламжийг барихад шаардагдах хөрөнгийг санхүүжүүлсэн иргэн, хуулийн этгээдийг; |
| Дүгнэлт: Барилгын тухай хуульд “46.3.Хөрөнгө оруулагч, захиалагч ашиглалтад оруулсан барилга байгууламжийн газрын зөвшөөрөл, тэг тэнхлэг таталтын акт, зураг төсөл, ил, далд ажлын акт, гадна шугам сүлжээний гүйцэтгэлийн зураг, барилгын ажлын явцад захиалагч, зохиогч, барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чанар, аюулгүй байдлын талаар гаргасан дүгнэлт, ашиглалтад оруулсан баримт бичгийг тухайн барилга байгууламжийг ашиглалтад оруулснаас хойш 30 өдөрт багтаан холбогдох төрийн архивт шилжүүлнэ.” гэснээс бусдаар "барилгын хөрөнгө оруулагч" гэсэн нэр томъёотой холбоотой үр дагаврын зохицуулалтыг төдийлөн тодорхой тусгаагүй байна. | |
| Санал: Барилгын хөрөнгө оруулагчтай холбоотой үр дагаврын зохицуулалтыг тодорхой тусгаж өгөх. | |

| | |
|----------|---|
| № | Барилгын тухай 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ |
|----------|---|

| | |
|-----------|---|
| 8. | <p>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт</p> <p>4.1.23."бие даасан эх үүсвэр, шугам сүлжээ" гэж тухайн барилга байгууламжийн хэрэгцээг хангахад зориулан барих ус, дулаан, уур, хий, цахилгаан, харилцаа холбоо зэрэг инженерийн хангамжийн шугам сүлжээ, байгууламжийг;</p> <p>Дүгнэлт: Барилгын тухай хуульд "шугам сүлжээ" гэснийг хэд хэдэн газар дурдаж оруулсан байх бөгөөд "бие даасан эх үүсвэр..." гэсэн нэр томьёотой холбоотой үр дагаврын зохицуулалтыг төдийлөн тодорхой тусгаагүй байна.</p> <p>Санал: Бие даасан эх үүсвэртэй холбоотой үр дагаврын зохицуулалтыг тодорхой тусгаж өгөх, эсхүл хуулиас хасах.</p> |
|-----------|---|

| | |
|-----------|--|
| № | <p>Барилгын тухай 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/</p> |
| 9. | <p>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт</p> <p>4.1.25."гадна тохижилтын ажил" гэж барилга байгууламжийн гаднах талбайн ногоон байгууламж, автозам, зогсоол, явган хүний зам, гарц, оршин суугчдын амрах болон хүүхдийн тоглоомын талбай, уран барилгын жижиг хэлбэр, гэрэлтүүлэг зэргийг барьж байгуулах үйл ажиллагааг;</p> <p>Дүгнэлт: Барилгын тухай хуульд "гадна тохижилтын ажил" гэсэн нэр томьёотой холбоотой үр дагаврын зохицуулалт байхгүй байна.</p> <p>Санал: Гадна тохижилтын ажилтай холбоотой үр дагаврын зохицуулалтыг хуульд тодорхой тусгаж өгөх.</p> |

| | |
|------------|---|
| № | <p>Барилгын тухай 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/</p> |
| 10. | <p>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт</p> <p>4.1.33."инженерийн дэд бүтэц" гэж авто зам, төмөр зам, дүүжин зам, газрын доор, дээр байрлах замын байгууламж, бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтээц бүхий байгууламжийг;</p> <p>Дүгнэлт: Барилгын тухай хуульд "инженерийн дэд бүтэц" гэсэн нэр томьёотой холбоотой үр дагаврын зохицуулалт байхгүй байна.</p> <p>Санал: Барилгын тухай хуульд "инженерийн дэд бүтэц" гэсэн нэр томьёотой холбоотой үр дагаврын зохицуулалтыг тодорхой тусгаж өгөх.</p> |

| | |
|------------|--|
| № | <p>Барилгын тухай 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/</p> |
| 11. | <p>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт</p> <p>4.1.37."төвлөрсөн бус инженерийн шугам сүлжээ" гэж тодорхой талбай, эсхүл барилга байгууламжид ус, дулаан, уур, хий, цахилгаан, харилцаа холбооны үйлчилгээ нийлүүлэх зориулалт бүхий байгууламжийг;</p> <p>Дүгнэлт: Барилгын тухай хуульд "төвлөрсөн бус инженерийн шугам сүлжээ" гэсэн нэр томьёотой холбоотой үр дагаврын зохицуулалт байхгүй байна.</p> |

Санал: Барилгын тухай хуульд "төвлөрсөн бус инженерийн шугам сүлжээ" гэсэн нэр томъёотой холбоотой үр дагаврын зохицуулалтыг тодорхой тусгаж өгөх.

| | |
|---|---|
| № | Барилгын тухай 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ |
| 12. | 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 4.1.38."төвлөрсөн инженерийн шугам сүлжээ" гэж төв суурин газар, түүний тодорхой хэсэгт орших барилга байгууламжийг ус, дулаан, уур, хий, цахилгаан, харилцаа холбооны төвлөрсөн эх үүсвэртэй холбох үндсэн байгууламжийг; |
| Дүгнэлт: Барилгын тухай хуульд "төвлөрсөн инженерийн шугам сүлжээ" гэсэн нэр томъёотой холбоотой үр дагаврын зохицуулалт байхгүй байна. | |
| Санал: Барилгын тухай хуульд "төвлөрсөн инженерийн шугам сүлжээ" гэсэн нэр томъёотой холбоотой үр дагаврын зохицуулалтыг тодорхой тусгаж өгөх. | |

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 | Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль | “Алсын хараа – 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа | “Алсын хараа- 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого |
|------------|---|--|--|--|
| 13. | 11 дүгээр зүйл. Барилгын үйл ажиллагааны зарчим 11.1.7.барилгын үйл ажиллагаанд ногоон хөгжлийн бодлого, <u>ногоон барилгын</u> шаардлагыг хэрэгжүүлэх: дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, цахилгаан, дулаан, уур, усны эх үүсвэрийг үр ашигтай төлөвлөх. | Зохицуулалт байхгүй. | Зорилт 6.4 6.4.3.Тогтвортой ногоон хот, <u>ногоон барилга</u> , амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг дэмжин хөгжүүлнэ. 6.4.10.Барилгын салбарт <u>ногоон, эрчим хүчний</u> хэмнэлттэй бүтээгдэхүүн үйлдвэрлэгч дотоодын үйлдвэрүүдийг дэмжин хөгжүүлнэ. | Зорилт 9.2 9. <u>Ногоон барилгын</u> стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлнэ. |

Дүгнэлт: Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.7 дахь хэсэгт барилгын үйл ажиллагаанд ногоон барилгын шаардлагыг хэрэгжүүлэх гэж хуульчилсан байна. Монгол улсын бусад хууль тогтоомжид ногоон барилгын талаар зохицуулсан зохицуулалт байхгүй байна. Харин “Алсын хараа – 2050”-ийн урт хугацааны хөгжлийн бодлогын 9.2 дахь зорилтод ногоон барилгын стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлэх талаар тусгасан байна.

Барилгын тухай хууль болон Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль, болон бусад холбогдох хуулиудад үр дагаврын зохицуулалт байхгүй байна.

Санал: Барилгын тухай хуулийн 11-р зүйлийн 11.1.7 дахь хэсэгт тусгасан ногоон барилгын шаардлагыг хэрэгжүүлэхэд үр дагаврын зохицуулалтыг тусгах, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуульд холбогдох зохицуулалтыг оруулах.

| | |
|------------|---|
| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ |
| 14. | 13 дугаар зүйл. Барилгын материал, бүтээгдэхүүнд тавих шаардлага 13.1.1.барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг, зураг төслийн шаардлагыг бүрэн хангасан байх; Дүгнэлт: Барилгын материал, бүтээгдэхүүний стандартын шаардлагыг орхигдуулсан байна. Барилгын материал, бүтээгдэхүүн нь стандартын шаардлага хангасан байх ёстой. Санал: Хуулийн 13.1.1-д стандартын шаардлагыг нэмж тусгах. |

| | |
|------------|--|
| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ |
| 15. | 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь барилгын үйл ажиллагаа эрхлэх, барилгын материал үйлдвэрлэх, барилгын ажил гүйцэтгэх, түүнд хяналт тавих, ашиглалтад оруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Дүгнэлт: Барилгын тухай хуульд "барилгын ажил гүйцэтгэх" гэж 24 удаа дурдагдсан байна, гэхдээ хуульд энэ талаарх нэр томъёоны тодорхойлолт байхгүй байна. Барилгын үйл ажиллагаа, засвар, шинэчлэх, барилгын ажил эхлүүлэх зэргийг тодорхойлсон байх бөгөөд тус хуульд барилгын ажил гүйцэтгэх гэсэн чухал асуудлыг тодорхойлохыг орхигдуулсан байна. Санал: БТХ-ийн нэр томъёоны тодорхойлолтын 4 дүгээр зүйлд "барилгын ажил гүйцэтгэх" талаар тодорхойлолт нэмж тусгах. |

| | |
|------------|--|
| № | Барилгын тухай 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ |
| 16. | 23 дугаар зүйл. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах 23.2.Энэ хуулийн 23.1-д заасны дагуу баталгаажуулсан барилга байгууламжийн байршил, загвар зураг, техникийн нөхцөлүүдэд үндэслэн эх загвар зураг /эскиз/, иж бүрэн ажлын зураг төслийг боловсруулна. 23.3.Энэ хуулийн 23.2-т заасан иж бүрэн ажлын зураг төслийг дараахь үе шатаар боловсруулна. 23.3.1.энэ хуулийн 10.1.5-д заасан ангилалын болон цогцолбороор баригдах барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлыг "техникийн зураг", "ажлын зураг" гэсэн хоёр үе шатаар; Дүгнэлт: Барилгын тухай хуулийн 23 дугаар зүйлд "ажлын зураг төсөл"-ийг тусгасан байна. Тус ажлын зураг төслийн талаар нэр томъёоны тодорхойлолт нь Барилгын тухай хуульд байхгүй байна. Санал: Барилгын тухай хуульд "ажлын зураг төсөл" гэсэн нэр томъёог тусгах. |

| | |
|----------|---|
| № | Барилгын тухай 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ |
|----------|---|

| | |
|------------|---|
| 17. | <p>25 дугаар зүйл. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх</p> <p>25.2.Магадлалыг дараахь зураг төсөлд хийнэ: 25.2.1.газар хөдлөлтийн долоо ба түүнээс дээш баллын бүсэд баригдах энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл, инженерийн тооцоо, өртгийн төсөвт;</p> <p>Дүгнэлт: Барилгын тухай хуульд бусад ангиллын 7-оос доош баллтай олон нийтийн барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх эсэх нь тодорхойгүй, энэ талаарх зохицуулалт байхгүй байна.</p> <p>Санал: Барилгын тухай хуульд 7-оос доош баллын бүсэд баригдах барилга байгууламжид магадлал хийх талаар зохицуулалтыг тусгах.</p> |
|------------|---|

| | |
|------------|---|
| № | <p>Барилгын тухай 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/</p> |
| 18. | <p>25 дугаар зүйл. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх</p> <p>25.5.Барилгын ажлын явцад барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцэд өөрчлөлт оруулсан бол тухайн өөрчлөлтийг тусгаж боловсруулсан зураг төсөлд дахин магадлал хийлгэнэ.</p> <p>Дүгнэлт: Барилгын ажлын явцад барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцэд өөрчлөлт оруулсан бол магадлалаар оруулна гэсэн байна. Төрийн эрх бүхий байгууллагаас өгсөн төлөвлөлтийн даалгавартай зөрчилддөг. Тус зохицуулалтад магадлалаар оруулна гэж зааснаар барилгын зориулалтыг өөрчлөх боломжийг олгож байна. Тус зохицуулалтад эрх бүхий байгууллагаас олгосон төлөвлөлтийн даалгавартай зөрчилдвөл дахин зөвшөөрөл авах талаар дурдаагүй бөгөөд энэ заалт нь хийдэл үүсгэж байна.</p> <p>Санал: Барилгын тухай хуульд барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцэд өөрчлөлт оруулсан бол зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагаас дахин зөвшөөрөл олгодог байхаар тусгах.</p> |

| | |
|------------|---|
| № | <p>Барилгын тухай 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/</p> |
| 19. | <p>28 дугаар зүйл. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгох</p> <p>28.2.Барилгын ажлын зөвшөөрөл авах хүсэлтэд дараахь баримт бичгийг хавсаргана.</p> <p>Дүгнэлт: Барилгын тухай хуулийн 28-р зүйлийн 28.2 дахь хэсэгт шинэ барилга байгууламжид бүрдүүлэх материалын жагсаалтыг тусгасан боловч барилга байгууламжийн буулгалтын ажил, тохижилтын ажлын зохицуулалт байхгүй байна.</p> <p>Санал: Барилгын тухай хуульд барилга байгууламжийг буулгалтын ажил, тохижилтын ажилд бүрдүүлэх баримт бичгийг тусгах.</p> |

| | |
|------------|--|
| № | <p>Барилгын тухай 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/</p> |
| 20. | <p>40 дүгээр зүйл. Барилгын ажил гүйцэтгэгчийн чиг үүрэг</p> <p>40.1.24. энэ хуулийн 10.1.1-д заасан ангилалд хамаарах барилгын ажлыг холбогдох зөвшөөрөлгүйгээр иргэн, хуулийн этгээд гүйцэтгэж болно. Энэ тохиолдолд барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг дагаж мөрдөх.</p> |

Дүгнэлт: Барилгын тухай хуулийн 10.1.1 дэх хэсэгт дурдсан “холбогдох зөвшөөрөлгүйгээр” гэсэн үг энэ ангилалд байх барилгыг барихад зөвшөөрөл авахгүй бөгөөд архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зургийг шаардахгүй байх агуулга гарч байна. Тус заалтаас үүдэн барилгыг зөвшөөрөлгүй барихдаа хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөгөөр зам төлөвлөсөн газар, эсвэл төлөвлөсөн шугамын трасс дээр барих эрхийг энэ хуульд зөвшөөрчихсөн. Тус зохицуулалт нь хуулийн хийдэл үүсгэж байна.

Санал: Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.24 дэх хэсэгт “холбогдох зөвшөөрөлгүйгээр” гэсэн үгийг “барилгын ажлын зөвшөөрөлгүйгээр” гэж найруулбал архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зургаа батлуулах зохицуулалттай болно. Барилгын тухай хуулийн 40.1.24 дэх хэсэгт “холбогдох зөвшөөрөлгүйгээр” гэсэн үгийг “барилгын ажлын зөвшөөрөлгүйгээр” гэж найруулах.

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | Автозамын тухай хууль 2017.05.11 /Шинэчилсэн найруулга/ |
|-----|---|--|
| 21. | <p>4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>4.1.1."барилга байгууламж" гэж орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээг; <u>/Энэ заалтад 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</u></p> | <p>2 дугаар зүйл. Авто замын тухай хууль тогтоомж</p> <p>2.1.Авто замын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Авто тээврийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.</p> |

Дүгнэлт: Барилгын тухай хуульд 2017.05.17-нд буюу Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлах үед өөрчлөлт оруулж "барилга байгууламж" гэсэн нэр томъёоны тодорхойлолтоос “зам гүүр” гэсэн үгийг хассан байна. Энэхүү өөрчлөлт нь жижиг өөрчлөлт мэт боловч бодлогын хувьд барилга болон авто замын салбарын харилцан уялдааг алдагдуулсан зүйл болсон гэж дүгнэж байна. Авто зам бол барилга байгууламж, барилгын ажлын нэг хэсэг байдаг бөгөөд Авто замын тухай хуульд “барилга” гэсэн үг зохицуулалтын хувьд 28 удаа тусгагдсан байна. Гэвч хууль тогтоомжийн бүрдэл болон авто замын салбарын дүрэм журам батлах, авто замыг ашиглалтад хүлээж авах зохицуулалтуудад Барилгын тухай хууль, барилгын салбарын оролцоог орхигдуулсан нь бодлогын зохицуулалтын хувьд томоохон дутагдал, хуулийн бичвэрийн талдаа хийдлийг бий болгосон байна.

Санал: Иймд, Авто замын тухай хуулийн 2.1 дэх хэсэгт Барилгын тухай хуулийг нэмж оруулах шаардлагатай байна.

| № | Автозамын тухай хууль 2017.05.11 /Шинэчилсэн найруулга/ |
|-----|---|
| 22. | <p>8 дугаар зүйл. Авто замын норм, норматив, техникийн баримт бичиг, норм, нормативын сан</p> <p>8.2.Авто замын норм, норматив, техникийн баримт бичгийг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, холбогдох эрх бүхий байгууллага батална.</p> |
| 23. | 19 дүгээр зүйл. Авто зам, замын байгууламжийн зураг төсөл |

| | |
|---|--|
| | 19.3.Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. |
| 24. | 21 дүгээр зүйл. Авто замын барилгын ажлын техник, технологийн хяналт 21.2.Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. |
| 25. | 22 дугаар зүйл. Авто замын арчлалт, засварын ажил 22.8.Авто замын ашиглалтын бэлэн байдлын түвшингээр санхүүжүүлэх норм, норматив болон журмыг санхүү, төсвийн болон авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. |
| 26. | 28 дугаар зүйл. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах 28.3.Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. |
| 27. | 31 дүгээр зүйл. Авто зам, замын байгууламжийг хаах 31.2.Авто зам, замын байгууламжийг хаах, замын чиглэл өөрчлөх журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. |
| 28. | 28 дугаар зүйл. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах 28.1.Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замыг ашиглалтад авах асуудлыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах асуудлыг тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцан зохион байгуулна. |
| <p>Дүгнэлт: 1/ Барилгын тухай хуульд 2017.05.17-нд буюу Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлах үед өөрчлөлт оруулж "барилга байгууламж" гэсэн нэр томъёоны тодорхойлолтоос "зам гүүр" гэсэн үгийг хассан байна. Энэхүү өөрчлөлт нь жижиг өөрчлөлт мэт боловч бодлогын хувьд барилга болон авто замын салбарын харилцан уялдааг алдагдуулсан зүйл болсон гэж дүгнэж байна. Авто зам бол барилга байгууламж, барилгын ажлын нэг хэсэг байдаг бөгөөд Авто замын тухай хуульд "барилга" гэсэн үг зохицуулалтын хувьд 28 удаа тусгагдсан байна. Гэвч хууль тогтоомжийн бүрдэл болон авто замын салбарын дүрэм журам батлах, авто замыг ашиглалтад хүлээж авах зохицуулалтуудад Барилгын тухай хууль, барилгын салбарын оролцоог орхигдуулсан нь бодлогын зохицуулалтын хувьд томоохон дутагдал, хуулийн бичвэрийн талдаа хийдлийг бий болгосон байна.</p> <p>2/ Авто замын тухай хуулийн 8.2, 19.3, 21.2, 22.8, 28.3 болон 31.2 дахь хэсэгт заасан норм, норматив, техникийн баримт бичиг, журмуудыг зөвхөн авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дангаар батлахаар тусгасан байна. Гэтэл эдгээр асуудлуудад барилгын салбар, барилгын мэргэжилтнүүдийн оролцоо зайлшгүй чухал юм.</p> <p>3/ Авто замын тухай хуулийн 28.1 дэх хэсэгт олон улсын болон орон нутгийн чанартай авто замыг ашиглалтад хүлээн авахад барилгын салбарын оролцоог мөн орхигдуулсан байна.</p> <p>Санал: Авто замын тухай хуулийн 8.2, 19.3, 21.2, 22.8, 28.3 болон 31.2 дахь хэсэгт "барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн" гэж, мөн хуулийн 28.1 дэх хэсэгт "барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага" гэж тус тус нэмэлт оруулах. Барилгын тухай хуульд мөн Авто замын салбартай холбоотой уялдуулсан зохицуулалт тусгах шаардлагатай байна.</p> | |

| | |
|------------|---|
| № | Усны тухай хууль 2012.05.17 /Шинэчилсэн найруулга/ |
| 29. | 10 дугаар зүйл.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх |

| | |
|------------|--|
| | 10.1.3.усны нөөцийг тооцоолох, усны тоо бүртгэл явуулах, усны нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээг тогтоох, усны хэрэглээний норм тогтоох, усны чанарыг бохирдлын индексээр үнэлэх, усны сан бүхий газрыг нөхөн сэргээх, уст цэг, усны барилга байгууламжийг ашиглах, эзэмших, ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулахтай холбогдсон журам, зааврыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, батлах. |
| 30. | 12 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх 12.1.3.ус, усан орчинг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, усны барилга байгууламжийг барихтай холбогдсон үйл ажиллагааг зохион байгуулах; |
| 31. | 32 дугаар зүйл.Усны барилга байгууламж 32.10.Усны аливаа барилга байгууламж нь паспорттай байна. |

Дүгнэлт: 1/ Усны барилга байгууламж бол барилгын ажлын нэг хэсэг байдаг бөгөөд Усны тухай хуульд “барилга” гэсэн үг зохицуулалтын хувьд 38 удаа тусгагдсан байна. Гэвч хууль тогтоомжийн бүрдэл болон усны салбарын барилга байгууламжийн талаар дүрэм журам батлах, зохицуулалтуудад Барилгын тухай хууль, барилгын салбарын оролцоог орхигдуулсан нь бодлогын зохицуулалтын хувьд томоохон дутагдал, хуулийн бичвэрийн талдаа хийдлийг бий болгосон байна.

2/ Мөн усны барилга байгууламжийг ашиглалтад хүлээж авах зохицуулалт байхгүй байна.

3/ Усны тухай хуулийн 10.1.3 дахь хэсэгт заасан норм, норматив, баримт бичиг, журмуудад “усны барилга байгууламж”-ийг барих талаар зохицуулалт байхгүй бөгөөд журмыг зөвхөн усны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага хамтран батлахаар тусгасан байна. Гэтэл эдгээр асуудлуудад барилгын салбар, барилгын мэргэжилтнүүдийн оролцоо зайлшгүй чухал юм.

4/ Усны тухай хуулийн 12.1.3 дахь хэсэгт усны барилга байгууламж барихад барилгын салбарын оролцоог мөн орхигдуулсан байна.

5/ Усны тухай хуулийн 32.10 дахь хэсэгт усны аливаа барилга байгууламжийг хэн, хэрхэн паспортжуулах процессын зохицуулалт байхгүй байна.

Санал: Усны тухай хуулийн 10.1.3 дахь хэсэгт “барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, мөн хуулийн 12.1.3 дахь хэсэгт “барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага”-ын оролцоог хангах, 32.10 дахь хэсэгт гэрчилгээжүүлэх, түүнийг бүртгэх, гэрчилгээ олгох гэх үргэлжилсэн процессын зохицуулалтыг тусгах. Мөн Барилгын тухай хуульд усны барилга байгууламжтай холбоотой уялдуулсан зохицуулалт тусгах шаардлагатай байна.

| № | Эрчим хүчний тухай хууль 2001.02.01 |
|------------|---|
| 32. | 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь эрчим хүчний нөөцийг ашиглан эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагаа эрхлэх, эрчим хүчний барилга байгууламж барих болон эрчим хүчийг хэрэглэхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино. |
| 33. | 6 дугаар зүйл.Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 6.1.5.нэгдсэн сүлжээ, хийн хангамж, төвлөрсөн дулаан хангамжийн дүрэм, эрчим хүчний барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралт, засвар, ашиглалт, аюулгүй ажиллагааны болон магадлал хийх дүрэм, журам батлах, хэрэглэгчийн зэрэглэлийг тогтоох; |
| 34. | 12 дугаар зүйл.Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, түүнийг олгох 12.2.Улсын хилийг дайран өнгөрөх шугам, 5 МВт-аас дээш хүчин чадалтай эрчим хүчний барилга байгууламж барих, диспетчерийн зохицуулалт хийх тусгай |

| | |
|--|--|
| | зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр Зохицуулах хороо олгоно. |
| <p>Дүгнэлт: 1/ Эрчим хүчний барилга байгууламж бол барилгын нэг төрөл бөгөөд барилга байгууламжийн хамгийн анхаарах ёстой салбар юм. Эрчим хүчний тухай хуульд “барилга” гэсэн зохицуулалтын хувьд 27 удаа тусгагдсан байна.</p> <p>Гэвч хууль тогтоомжийн бүрдэл болон эрчим хүчний салбарын барилга байгууламжийн талаар дүрэм журам батлах, зохицуулалтуудад Барилгын тухай хууль, барилгын салбарын оролцоог орхигдуулсан нь бодлогын зохицуулалтын хувьд дутагдал, хуулийн бичвэрийн талдаа хийдлийг бий болгосон байна.</p> <p>2/ Эрчим хүчний тухай хуулийн 1.1 дэх хэсэгт “... эрчим хүчний барилга байгууламж барих ...” гэж тусгажээ. Гэвч тус хуулийн 2 дугаар зүйлд “Эрчим хүчний барилга байгууламжийг барихтай холбогдсон харилцааг Барилгын тухай хуулиар зохицуулна” гэсэн агуулга бүхий зохицуулалт байхгүй. Өөрөөр хэлбэл эрчим хүчний барилга байгууламжийг барих зохицуулалт хангалтгүй харагдаж байна.</p> <p>3/ Эрчим хүчний тухай хуулийн 6.1.5 дахь хэсэгт заасан дүрэм, журмуудыг Төрийн захиргааны төв байгууллага батлахаар тусгасан байна. Гэтэл хуулийн 6.1.5-д эрчим хүчний барилга байгууламжийг барих дүрэм журмыг батлах асуудалд барилгын салбар, барилгын мэргэжилтнүүдийн оролцоо зайлшгүй чухал юм.</p> <p>4/ Эрчим хүчний тухай хуулийн 12.2-т заасан “улсын хилийг дайран өнгөрөх шугам, 5 МВт-аас дээш хүчин чадалтай эрчим хүчний барилга байгууламж барих, диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрлийг” олгоход барилгын салбарын оролцоог орхигдуулсан байна.</p> <p>Санал: Эрчим хүчний тухай хуулийн 2 дугаар зүйлд нэмэлтээр “Эрчим хүчний барилга байгууламжийг барихтай холбогдсон харилцааг Барилгын тухай хуулиар зохицуулна” гэсэн агуулга бүхий зохицуулалт тусгах, хуулийн 6.1.5 дахь хэсэг болон 12.2 дахь хэсэгт “барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж нэмэх. Барилгын тухай хуульд мөн эрчим хүчний барилга байгууламжтай холбоотой уялдуулсан зохицуулалт тусгах шаардлагатай.</p> | |

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | Эрчим хүчний тухай хууль 2001.02.01 |
|---|--|---|
| 35. | Зохицуулалт байхгүй. | 32 дугаар зүйл. Усны барилга байгууламж 32.2. Энэ хуулийн 32.8-д зааснаас бусад улсын чанартай усны барилга байгууламж барих шийдвэрийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, сав газрын захиргааны дүгнэлт, аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг үндэслэн барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана. |
| <p>Дүгнэлт:</p> <p>1/ Усны тухай хуулийн 32.2 дахь хэсэгт усны барилга байгууламж барих шийдвэрийг Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргахаар хуульчилсан байна.</p> <p>Гэвч барилгын тухай хуульд усны барилга байгууламжийг барих шийдвэрийг гаргахаар тусгасан зохицуулалт байхгүй байна. Барилгын тухай хуульд байх ёстой байх шаардлагатай зохицуулалт тусгагдаагүй байна.</p> <p>Санал: Барилгын тухай хуульд Усны барилга байгууламжийг барихтай холбоотой шийдвэрийг гаргах зохицуулалтыг тусгах.</p> | | |

| № | Барилгын тухай хууль 2016.02.05 | Эрчим хүчний тухай хууль | Зөвшөөрлийн тухай хууль |
|---|------------------------------------|-----------------------------|----------------------------|
|---|------------------------------------|-----------------------------|----------------------------|

| | | 2001.02.01 | |
|---|---|--|---|
| 36. | 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 4.1.30."зураг төсөл" гэж барилга байгууламжийг төлөвлөх, барилгын ажил гүйцэтгэхэд шаардагдах загвар зураг, эх загвар зураг /эскиз/, техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон ажлын зураг, барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын төсөл, инженер хайгуулын судалгаа, инженер геологи, геодезийн зураглал, инженерийн тооцоо, өртгийн төсөв зэрэг баримт бичгийн иж бүрдлийг; | “Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл” гэсэн нэр томъёоны тайлбар болон зураг төсөл боловсруулах журмыг батлах талаар зохицуулалт байхгүй. | 14.Эрчим хүчний чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно: 14.22.эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах - эрхийг – Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| Дүгнэлт: Эрчим хүчний тухай хуульд зураг төслийн талаар тодорхойлолт болон Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах журам батлах талаар ямар ч зохицуулалт байхгүй боловч Зөвшөөрлийн тухай хуульд Эрчим хүчний яам нь “14.22.эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах” эрх олгохоор тусгасан байна. | | | |
| Санал: Эрчим хүчний тухай хуульд “Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл” гэж Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасныг гэж эшлэх, нэр томъёоны тодорхойлолт оруулах, Холбогдох журмыг батлахдаа Барилгын яамны оролцоог нэмэх шаардлагатай байна. | | | |

| № | Төмөр замын тээврийн хууль 2023.07.07 /Шинэчилсэн найруулга/ | | |
|------------|---|--|--|
| 37. | 8 дугаар зүйл.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 8.1.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.1.4.төмөр замын суурь бүтэц, салбар замын барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, ашиглалтад оруулахтай холбоотой ажлыг зохион байгуулах; | | |
| 38. | 10 дугаар зүйл.Төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг 10.2.11.төмөр замын суурь бүтэц, салбар зам, барилга байгууламжийг барих, өргөтгөх ажилд хяналт тавих; 10.2.15.төмөр замын зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулж хүн, хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, шинжээчийн эрх олгох; | | |
| 39. | 11 дүгээр зүйл.Төмөр замын тээврийн дүрэм, журам 11.1.Төмөр замын тээврийн салбарт дараах дүрэм, журам, аргачлал, нормыг баталж мөрдүүлнэ: 11.1.5.төмөр замын барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам; 11.1.6.төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, магадлал хийх, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээний журам; 11.1.21.төмөр замын барилга байгууламжийн ажлын төсвийн суурь норм; 11.1.25.Төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартын сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам; | | |

| | |
|---|---|
| | <p>11.2.Энэ хуулийн 11.1.1, 11.1.2, 11.1.3-т заасан дүрэм, 11.1.4, 11.1.5, 11.1.7, 11.1.8, 11.1.9, 11.1.12, 11.1.14, 11.1.17, 11.1.25, 11.1.27-д заасан журам, 11.1.20-д заасан аргачлал, 11.1.21-д заасан нормыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, энэ хуулийн 11.1.6, 11.1.10, 11.1.11, 11.1.13, 11.1.16, 11.1.18, 11.1.19-д заасан журмыг төрийн захиргааны байгууллага тус тус батална.</p> <p>11.3.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 11.1.22, 11.1.23-т заасан журмыг тагнуулын байгууллагатай, энэ хуулийн 11.1.24-т заасан журмыг төрийн тусгай хамгаалалтын байгууллагатай, энэ хуулийн 11.1.26-д заасан журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй тус тус хамтран батална.</p> <p>11.4.Энэ хуулийн 11.1.15-д заасан журмыг төрийн захиргааны байгууллага тагнуулын байгууллагатай хамтран батална.</p> |
| 40. | <p>14 дүгээр зүйл.Төмөр замын тусгай зөвшөөрөл</p> <p>14.1.Төмөр замын тусгай зөвшөөрөл дараах төрөлтэй байна:</p> <p>14.1.1.төмөр замын суурь бүтэц барих, зураг төсөл боловсруулах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ;</p> <p>14.3.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5.1¹¹, 5.4, 5.6, 5.7-д заасан тусгай зөвшөөрөл хүсэгчид тавих нөхцөл, шаардлагыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.</p> |
| 41. | <p>22 дугаар зүйл.Төмөр замын суурь бүтцийн барилгын ажил</p> <p>22.1.Төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд захиалагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр холбогдох хууль тогтоомж, төмөр замын тээврийн дүрэм, журам, техникийн зохицуулалт, стандартын дагуу барьж гүйцэтгэнэ.</p> <p>22.2.Төмөр замын суурь бүтцийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг эрх бүхий мэргэжлийн байгууллага, захиалагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ.</p> |
| <p>Дүгнэлт: 1/ Төмөр зам бол барилга байгууламж, барилгын ажлын нэг хэсэг байдаг бөгөөд Төмөр замын тээврийн тухай хуульд “барилга” гэсэн үг зохицуулалтын хувьд 13 удаа дурдагдсан байна. Гэвч төмөр замын барилга байгууламжийг барих, суурь бүтцийг барих болон төмөр замын барилга байгууламжийн талаар дүрэм, журам батлах зохицуулалтуудад Барилгын тухай хууль, барилгын салбарын оролцоог орхигдуулсан нь бодлогын хувьд томоохон дутагдал, хуулийн бичвэрийн талдаа хийдлийг бий болгосон байна.</p> <p>2/ Төмөр замын тээврийн тухай хуулийн 8 болон 10 дугаар зүйлүүдэд төмөр замын тээврийн ТЗТБ болон ТЗБ-ын бүрэн эрх, чиг үүргийг тусгасан байх бөгөөд төмөр замын барилга байгууламжтай холбоотой чиг үүрэгт барилгын салбарын оролцоог хангаж байх зохицуулалт дутуу байна.</p> <p>3/ Төмөр замын тээврийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд төмөр замын тээврийн дүрэм, журмуудыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон ТЗТБ батлахаар тусгасан байна. Ингэхдээ хуулийн 11.3 болон 11.4-т тухайн журмуудыг хамтран батлах бусад төрийн байгууллагын оролцоог дурдсан хэдий ч барилгын салбарын оролцоог огт дурдаагүй байна. Ө.х. төмөр замын барилга байгууламж, барилгын ажилтай холбоотой дүрэм, журам боловсруулах, батлах үйл ажиллагаанд барилгын асуудал эрхэлсэн ТЗТБ-ыг оролцуулах шаардлагатай юм.</p> <p>4/ Төмөр замын тээврийн тухай хуулийн тусгай зөвшөөрлийн талаарх 14 дүгээр зүйлд мөн барилгын салбарын мэргэжлийн оролцоог орхигдуулсан байна.</p> <p>Санал: Төмөр замын тээврийн тухай хуулийн 8, 10, 11, 14, 22 дугаар зүйлүүдэд барилгын салбарын мэргэжлийн оролцоог тусгаж, “барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв</p> | |

11

| Тусгай зөвшөөрөл | Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд |
|-----------------------------------|---|
| 5.1.төмөр замын суурь бүтэц барих | Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |

байгууллага” гэж нэмэх. Барилгын тухай хуульд мөн төмөр замын барилга байгууламжтай холбоотой уялдуулсан зохицуулалт тусгах шаардлагатай.

| | |
|---|--|
| № | Боловсролын ерөнхий хууль 2023.07.07 /Шинэчилсэн найруулга/ |
| 42. | <p>39 дүгээр зүйл.Боловсролын сургалтын байгууллагын орчин 39.1.Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, номын сан, гал тогоо, биеийн тамирын заал, талбай, дотуур байр, усан хангамж, ариун цэврийн байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна. 39.2.Энэ хуулийн 39.1-д заасан орчны норм, нормативыг холбогдох хууль тогтоомж, боловсролын стандартыг үндэслэн боловсролын, эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.</p> |
| <p>Дүгнэлт: Боловсролын ерөнхий хуулийн 39.1 дэх хэсэгт боловсролын сургалтын байгууллагын орчны шаардлагыг тусгасан бөгөөд 39.1-д заасан орчны норм, нормативыг батлах асуудалд мөн л барилгын салбарын мэргэжлийн оролцоог орхигдуулсан дутагдал, хийдлийг бий болгосон байна.</p> | |
| <p>Санал: Боловсролын ерөнхий хуулийн 39.2 дахь хэсэгт “барилга, хот байгуулалтын” гэж нэмэх.</p> | |

| | | |
|---|--|--|
| № | Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/ | БАРИЛГЫН ТӨСӨВ ЗОХИОХ ДҮРЭМ /БХБС-ын 2020 оны 30 дугаар тушаалын хавсралт/ |
| 43. | <p>Барилгын тухай хуульд “магадлашгүй ажил”-ын талаар зохицуулалт байхгүй байна.</p> | <p>Найм. Магадлашгүй ажлын нөөц хөрөнгийг тодорхойлох</p> <p>8.1.Барилгын ажлыг гүйцэтгэх нөхцөл, төслийн шийдлийг тодотгосон үр дүнгээр барилгын ажлын явцад үүсдэг зураг төсөлд тусгагдаагүй барилгын ажлыг санхүүжүүлэх нөөц эх үүсвэрийг магадлашгүй ажлын зардал гэж нэрлэнэ. Магадлашгүй ажлын зардлыг нэгдсэн төсвийн 2-7 дугаар бүлгийн нийлбэр дүнгээс /барилга угсралтын ажлын төсөвт өртөг/ орон сууц, иргэний зориулалттай объектод 2 хувь, үйлдвэрийн зориулалттай объектод 3 хувь, онцгой төвөгшилтэй объект, усны барилга байгууламжийн I дүгээр ангийн үндсэн барилгад 10 хүртэл хувиар тус тус тооцно.</p> |
| <p>Дүгнэлт: БХБСайдын 2020 оны 30 дугаарын хавсралтаар батлагдсан “Барилгын төсөв зохион дүрэм”-д барилгын ажлын төсөвт “магадлашгүй ажил”-ыг тооцоолох талаар дурдсан байх бөгөөд “магадлашгүй ажил” гэсэн томъёоллоор 23 удаа дурдаж зохицуулалтыг тусгасан байна. Гэвч Барилгын тухай хуульд барилгын “магадлашгүй ажил”-д юуг ойлгох талаар тодорхойлолт байхгүй, ямар тохиолдолд магадлашгүй ажил гарах, хэрхэн зохицуулах талаарх үр дагаврын зохицуулалтыг тусгаагүй байна.</p> | | |
| <p>Санал: Барилгын тухай хуульд магадлашгүй ажил”-ын нэр томъёоны тодорхойлолтыг тусгаж, холбогдох үр дагаврын зохицуулалтыг нэмж оруулах.</p> | | |

ДӨРӨВ. НЭГДСЭН ДҮН, САНАЛ ДҮГНЭЛТ

НЭГДСЭН ДҮН

Барилгын тухай хуулийн давхардал, зөрчил, хийдлийн судалгааны ажлын нэгдсэн дүн: Барилгын тухай хуультай холбоотой нийт 14 давхардал, 17 зөрчил, 43 хийдэл буюу нийтдээ 74 давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэв.

| № | Шалгуур үзүүлэлт | Тоо |
|---|------------------|-----------|
| 1 | 7.1. Давхардал | 14 |
| 2 | 7.2. Зөрчил | 17 |
| 3 | 7.3. Хийдэл | 43 |
| 4 | НИЙТ ДҮН | 74 |

Аргачлалын шалгуур үзүүлэлтийн дагуу илэрсэн давхардал, зөрчил, хийдлийг дор хүснэгтээр үзүүлэв.

| Д/Д | ШАЛГУУР | ИЛЭРСЭН ТОО |
|-----------------------|--|----------------|
| 7.1. ДАВХАРДАЛ | | 14 |
| 1 | 7.1.1. тухайн хуульд байгаа зохицуулалтын бичвэрийг бусад хуульд давтан хуулбарлан хуульчилсан эсэх; | - |
| 2 | 7.1.2. тухайн хуульд байгаа зохицуулалтыг уг хуульд болон бусад хуульд бичвэрийн, эсхүл агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан эсэх; | 14 |
| 3 | 7.1.3. төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг хуульд давхардуулан хуульчилсан эсэх; | - |
| 4 | 7.1.4. тухайн хуулийн тодорхой зохицуулалтыг Улсын дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний давхардлыг арилгахад чиглэгдсэн эсэх. | - |
| 7.2. Зөрчил | | 17 |
| 5 | 7.2.1. тухайн зохицуулалт нь хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх; | 1 |
| 6 | 7.2.2. хуулийн “хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх; | - |
| 7 | 7.2.3. хуулийн зүйлийн нэр тухайн зүйлд байгаа хэсэг, заалтын агуулгын нийлбэртэй нийцэж байгаа эсэх; | - |
| 8 | 7.2.4. хуулийн зүйл, заалт, зохицуулалт нь хэл зүйн найруулгын хувьд салаа утгатай эсэх; | - |
| 9 | 7.2.5. хуульд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн болон бусад хуулийн нэр томъёотой зөрчилдөж байгаа эсэх; | 1 |
| 10 | 7.2.6. тодорхой асуудлыг гагцхүү тухайн хуулиар зохицуулахаар заасан боловч уг асуудлаар өөр журмыг өөр хуульд заасан эсэх; | - |
| 11 | 7.2.7. хуульд заасан эшлэл алдаатай эсэх; | 3 |
| 12 | 7.2.8. тухайн хуульд бусад хуулиас авсан эшлэлийн дугаар нь нөгөө хуульд байгаа зохицуулалттай нийцэж байгаа эсэх; | 5 |
| 13 | 7.2.9. татварынхаас бусад хуульд тогтоомжид албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх; | - |
| 14 | 7.2.10. тухайн хуульд тусгай зөвшөөрөл олгохоор заасан нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд туссан эсэх; | - |

| | | |
|--------------------|--|-----------|
| 15 | 7.2.11.өмчлөх эрхийг хязгаарласан буюу хязгаарлахад чиглэгдсэн эрх зүйн акт гаргах эрхийг бусад этгээдэд хуулиар олгосон эсэх; | - |
| 16 | 7.2.12.тухайн хуулийн тодорхой зохицуулалтыг Улсын дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний зөрчлийг арилгахад чиглэгдсэн эсэх; | - |
| 17 | 7.2.13. хуулийн зүйл, заалт нь тухайн хууль болон өөр хуулийн заалттай зөрчилдөж буй эсэх. | 7 |
| 7.3. Хийдэл | | 43 |
| 18 | 7.3.1.тухайн хуульд тодорхой харилцааг нарийвчлан хуулиар зохицуулахаар заасан бол уг нарийвчилсан зохицуулалт бүхий хууль батлагдсан эсэх; | - |
| 19 | 7.3.2.тухайн хуульд тодорхой харилцааны нарийвчилсан зохицуулалтыг батлах эрхийг төрийн бусад байгууллагад шилжүүлсэн бол уг нарийвчилсан зохицуулалт батлагдсан эсэх; | - |
| 20 | 7.3.3.тухайн хуульд заасан процедурын шинжтэй зохицуулалт нь ойлгомжтой, тасралтгүй үргэлжлэх боломжтой байдлаар томъёолсон эсэхийг тодорхойлох; | - |
| 21 | 7.3.4.тодорхой эрх, үүргийг хэрэгжүүлэх этгээд нь тодорхой эсэх; | 1 |
| 22 | 7.3.5.төрийн байгууллага, албан тушаалтнаас тодорхой асуудал шийдвэрлэхээр хуульд заасан бол уг асуудлыг шийдвэрлэх хугацааг тодорхой заасан эсэх; | - |
| 23 | 7.3.6.хуульд заасан хориглосон зохицуулалт нь түүнийг зөрчигч этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх; | 2 |
| 24 | 7.3.7.тухайн хуулийн тодорхой зохицуулалтыг Улсын дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний хийдлийг арилгахад чиглэгдсэн эсэх; | - |
| 25 | 7.3.8.хуульд байх шаардлагатай зохицуулалт тусгагдсан эсэх; | 40 |
| 26 | 7.3.9.хуулийн зүйл, заалт, зохицуулалт нь ойлгомжтой байгаа эсэх. | - |
| Нийт | | 74 |

Барилгын тухай хуулийг холбогдох бусад хуультай харьцуулан давхардал, зөрчил, хийдлийг тогтоох, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах ажлын хүрээнд Барилгын тухай хуулийг холбогдох бусад хууль тогтоомжтой харьцуулсны үндсэн дээр **НИЙТДЭЭ 74 давхардал, зөрчил, хийдлийг** илрүүллээ.

Үүнийг задалж харуулбал:

- Тухайн хууль болон бусад хуультай давхардал – 14
- Тухайн хууль болон бусад хуультай зөрчил – 17
- Барилгын тухай хуулийн хүрээнд хийдэл – 43 гэж тогтоосон болно

Барилгын тухай хуулийг холбогдох бусад хуультай харьцуулан давхардал, зөрчил, хийдлийг тогтоох, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах ажлын хүрээнд дараах санал, дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

Хуулийн давхардлын талаар

Барилгын тухай хуульд тусгасан зохицуулалтыг Орон сууцны тухай хууль, Ойн тухай хууль, Боловсролын тухай хуулиудад агуулгын хувьд давтан хуулбарлан хуульчилсан байна.

Иймд, хуулиуд хоорондын давхардлыг арилгах үүднээс саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- Барилгын тухай хуулийн 40.3 дахь хэсэгт Ойн тухай хуулийн 29.1.9 дэх заалтыг эшлэх;
- Барилгын тухай хууль болон Авто замын тухай хуулийн 4 дүгээр зүйл дэх зураг төсөл, зураг төслийн магадлал, зураг төсөл зохиогч зэрэг нэр томъёоны тодорхойлолтуудыг агуулгын хувьд давхардуулан тодорхойлсон байх тул Барилгын хуульд суурь тодорхойлолтыг үлдээж, Авто замын тухай хуульд Барилгын хуулийг эшлэх;
- Барилга ашиглалтад орсноор ашиглагч, өмчлөгч, эзэмшигч барилга байгууламжийн баримт бичгийг баяжуулж, хадгалах асуудлыг хариуцдаг. Иймд хуулийн 37.1.15 дахь заалтыг хүчингүй болгох;
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 5.1.3-д Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийг эшлэх;
- Орон сууцны тухай хуулийн 14.5-д Барилгын тухай хуулийн 46.1.7 дахь заалтыг эшлэх;
- Орон сууцны тухай хуулийн 15.1 дэх хэсэгт Барилгын тухай хуулийн 46.1.3 дахь заалтыг эшлэх;
- Орон сууцны тухай хуулийн 7.1.2-д Барилгын тухай хуулийн 33.1.2 дахь заалтыг эшлэх;
- Түүнчлэн, Барилгын тухай хуулийн 37.1.15 дахь заалтыг хүчингүй болгох, мөн тус хуулийн 5.1.2 дахь заалтаас “дүрэм” гэснийг, 28.3 дахь хэсгээс “зураг төсөл боловсруулсан болон” гэснийг тус тус хасах;
- Барилгын тухай хууль болон Хот байгуулалтын тухай хуульд “инженерийн дэд бүтэц” гэсэн ойлголтыг нэр томъёоны хувьд давхардуулан тодорхойлсон байх тул Хот байгуулалтын тухай хуульд инженерийн дэд бүтцийн тодорхойлолтыг бүх салбарт нийцсэн байдлаар сайжруулан томъёолж, Барилгын тухай хуульд Хот байгуулалтын тухай хуулийг эшэлж, зохицуулалтыг уялдуулах.

Хуулийн зөрчлийн талаар

Барилгын тухай хууль болон Газрын тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай, Орон сууцны тухай зэрэг дор дурдсан хуулиуд дахь зарим зохицуулалтууд хоорондоо зөрчилдсөн, мөн авсан эшлэл таарахгүй байна.

Иймд, хуулиуд хоорондын зөрчлийг арилгах үүднээс дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- Барилгын тухай хуульд “барилгын ажлын зөвшөөрөл”-ийн талаарх зохицуулалтад Зөвшөөрлийн хуультай нийцүүлж “энгийн зөвшөөрөл” гэж тодотгож нэмэх;
- Газрын тухай хуулийн 44¹.7-д Барилгын тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг эшлэх;
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 5 дугаар зүйлд Барилгын тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг эшлэх;
- Барилгын тухай хуулийн 17.3-д Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу “аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн” гэснийг “сум, дүүргийн засаг дарга” гэж өөрчлөх;
- Барилгын тухай хуулийн эшлэл авсан заалтыг засаж “47.5-д заасан” гэснийг “47.4-т заасан” гэж засах;
- БТХ-ийн 27.1.2-т тус хуулийн 10.1.5-д заасан барилга байгууламжийн зөвшөөрлийг БХБЯ олгохоор заасан бол Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 3.3-т барилгын төрлийг заалгүйгээр барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх энгийн зөвшөөрлийг тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга олгохоор заасан нь зөрчилтэй байна. Барилгын тухай хуульд барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл болон барилгын ажлын зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Зөвшөөрлийн хуультай нийцүүлэн тодорхой, ойлгомжтой болгож хуульчлах;
- Орон сууцны тухай хууль дахь алдаатай эшлэлийг засаж, 3.1.5-д Барилгын тухай хуулийн 4.1.25 дахь заалтыг эшлэх;
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль 2021 онд хүчингүй болсон тул Барилгын тухай хуулийн 7.4 дэх хэсэгт Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн холбогдох заалтаар өөрчилж, засах;
- Газрын тухай хуулийн 44¹.7-д авсан эшлэлийн дугаартай нийцэхгүй байх тул Барилгын тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг эшлэх.
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 5 дугаар зүйлд Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийг эшлэх;
- Барилгын тухай хуулийн 17.3-т Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу “аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн” гэснийг “сум, дүүргийн Засаг дарга” гэж өөрчлөх;
- Барилгын тухай хуульд “барилга байгууламжийг буулгах” талаар нэр томъёоны тодорхойлолтыг тусгаж, дэлгэрэнгүй зохицуулалтыг оруулахаас гадна Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд Барилгын хуультай нийцүүлсэн өөрчлөлтийг оруулах;
- Эрүүл ахуйн тухай хуулийн 5.4 дэх хэсэгт эшлэсэн заалтыг Барилгын тухай хуулийн 13 дугаар зүйл гэж өөрчлөх;

- Барилгын орчны тохижилт, гадна тохижилт зэрэг асуудлууд Барилгын тухай хуульд хэд хэдэн зүйл, хэсэгт зохицуулагдаж байх тул Эрүүл ахуйн тухай хуулийн 5.7 дахь хэсэгт Барилгын тухай хуульд заасны дагуу гэж өөрчлөх;
- СӨХЭЗБНЗОСБДӨЭХТухай хуулийн 7.2.9, 13.2.7 дахь заалтыг тус тус хүчингүй болгох;
- Зөрчлийн тухай хуулийн 12.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “зөвшөөрөлгүйгээр” гэснийг хасах;
- Барилгын тухай хууль болон холбогдох бусад хуульд ногоон байгууламжийн талаар харилцан уялдаатай, хэрэгжихүйц зохицуулалтыг тусгаж өгөх;
- Барилгын тухай хууль болон барилгын норм, дүрмийн хоорондын зохицуулалтыг уялдуулах, зөрчилдсөн заалтуудыг засах;

Хуулийн хийдлийн талаар

- 1) Хийдэл хэсэгт Барилгын тухай хуульд дурдсан бүх дүрэм, журам, норм нормативын баримт бичгийг шалгасан бөгөөд холбогдох байгууллагуудаас бүх баримт бичгийг баталсан байна.
- 2) Барилгын тухай хуулийн 34 дүгээр зүйлд барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын 16 чиг үүргийг тусгасан байх бөгөөд 2023 оны 9 сарын байдлаар барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байхгүй байна. Цаашдаа барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байгуулж, дээрх чиг үүргийн хэрэгжилтийг хангах нь зүйтэй юм.
- 3) Барилгын тухай хуульд зарим зохицуулалтыг орхигдуулсан, ялангуяа нэр томьёонд дурдагдсан ч хууль дотроо үр дагаврын зохицуулалт байхгүй хэд хэдэн нэр томьёонууд байна.

Иймд, Барилгын хууль дахь хийдлийг арилгах үүднээс дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- Улсын комисс шаардлага хангаагүй барилга байгууламжийг хүлээн авч акт гаргасан тохиолдолд зохицуулах харилцааг Барилгын тухай хуульд тусгах;
- Зөрчлийн тухай хуульд Барилгын тухай хуулийн 37.5 дахь¹² хэсгийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаарх нэмэлт зохицуулалтыг тодорхой тусгаж өгөх;
- Зөрчлийн тухай хууль болон БТХ-д Барилгын тухай хуулийн 14.4 дэх хэсгийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, авах арга хэмжээний талаарх нэмэлт зохицуулалтыг тодорхой тусгаж өгөх.
- Барилгын тухай хуульд “мэргэжлийн зөвлөл”-ийн талаар нэр томьёоны тодорхойлолтод оруулах, мөн “холбогдох мэргэжлийн зөвлөл”, “архитектор, инженерийн орон тооны бус мэргэжлийн зөвлөл”, “архитектор, инженерийн мэргэжлийн зөвлөл” гэж хэд хэдэн янзаар бичигдсэн байгааг хуульд тодорхой, ойлгомжтой зохицуулалтыг тусгаж өгөх;
- Барилгын тухай хуулийн 11-р зүйлийн 11.1.7 дахь хэсэгт тусгасан ногоон барилгын шаардлагыг хэрэгжүүлэхэд үр дагаврын зохицуулалтыг тусгах, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуульд холбогдох зохицуулалтыг оруулах;
- Барилгын тухай хуулийн 13.1.1-д стандартын шаардлагыг нэмж тусгах;

¹² 37.5.Газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл олгоогүй, зураг төсөл нь боловсруулагдаж дуусаагүй орон сууцны барилгад иргэдээс хөрөнгө төвлөрүүлэхийг хориглоно.

- Барилгын тухай хуулийн нэр томъёоны тодорхойлолтын 4 дүгээр зүйлд “барилгын ажил гүйцэтгэх” талаар тодорхойлолт нэмж тусгах;
- Авто замын тухай хуулийн 2.1 дэх хэсэгт Барилгын тухай хуулийг нэмж оруулах шаардлагатай;
- Авто замын тухай хуулийн 8.2, 19.3, 21.2, 22.8, 28.3 болон 31.2 дахь хэсэгт “барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж, мөн хуулийн 28.1 дэх хэсэгт “барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж тус тус нэмэлт оруулах, Барилгын тухай хуульд мөн авто замын салбартай холбоотой уялдуулсан зохицуулалт тусгах шаардлагатай;
- Усны тухай хуулийн 10.1.3 дахь хэсэгт “барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, мөн хуулийн 12.1.3 дахь хэсэгт “барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага”-ын оролцоог хангах, 32.10 дахь хэсэгт гэрчилгээжүүлэх, түүнийг бүртгэх, гэрчилгээ олгох гэх үргэлжилсэн процессын зохицуулалтыг тусгах. Мөн Барилгын тухай хуульд усны барилга байгууламжтай холбоотой уялдуулсан зохицуулалт тусгах;
- Эрчим хүчний тухай хуулийн 2 дугаар зүйлд нэмэлтээр “Эрчим хүчний барилга байгууламжийг барихтай холбогдсон харилцааг Барилгын тухай хуулиар зохицуулна” гэсэн агуулга бүхий зохицуулалт тусгах, хуулийн 6.1.5 дахь хэсэг болон 12.2 дахь хэсэгт “барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж нэмэх, мөн Барилгын тухай хуульд мөн эрчим хүчний барилга байгууламжтай холбоотой уялдуулсан зохицуулалт тусгах;
- Барилгын тухай хуульд Усны барилга байгууламжийг барихтай холбоотой шийдвэрийг гаргах зохицуулалтыг тусгах;
- Эрчим хүчний тухай хуульд “Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл” гэж Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасныг гэж эшлэх, нэр томъёоны тодорхойлолт оруулах, холбогдох журмыг батлахдаа Барилгын яамны оролцоог нэмэх;
- Төмөр замын тээврийн тухай болон Боловсролын ерөнхий хуульд барилгын салбарын мэргэжлийн оролцоог нэмж тусгах;
- Барилгын тухай хуульд магадлашгүй ажил”-ын нэр томъёоны тодорхойлолтыг тусгаж, холбогдох үр дагаврын зохицуулалтыг нэмж оруулах.
- Барилгын тухай хуульд "барилга байгууламжийг ашиглалтад оруулсан гэрчилгээ", "барилгын хөрөнгө оруулагч" зэрэг нэр томъёотой холбоотой үр дагаврын зохицуулалтыг тодорхой тусгаж өгөх;
- Барилгын тухай хуульд “бие даасан эх үүсвэр” гэсэн нэр томъёотой холбоотой үр дагаврын зохицуулалтыг тодорхой тусгаж өгөх, эсхүл хуулиас хасах;
- Барилгын тухай хуульд "гадна тохижилтын ажил" гэсэн нэр томъёотой холбоотой үр дагаврын зохицуулалтыг тодорхой тусгаж өгөх;
- Барилгын тухай хуульд "инженерийн дэд бүтэц", "төвлөрсөн болон төвлөрсөн бус инженерийн шугам сүлжээ" зэрэг нэр томъёотой холбоотой үр дагаврын зохицуулалтыг тодорхой тусгаж, ялгамжтай байдлаар зохицуулах;
- Барилгын тухай хуульд "ажлын зураг төсөл" гэсэн нэр томъёог тусгах.
- Барилгын тухай хуульд 7-оос доош баллын бүсэд баригдах барилга байгууламжид магадлал хийх талаар зохицуулалтыг тусгах.
- Барилгын тухай хуульд барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцэд өөрчлөлт оруулсан бол зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагаас дахин зөвшөөрөл олгодог байхаар тусгах.
- Барилгын тухай хуульд барилга байгууламжийг буулгалтын ажил, тохижилтын ажилд бүрдүүлэх баримт бичгийг тусгах.
- Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.24 дэх хэсэгт “холбогдох зөвшөөрөлгүйгээр” гэсэн үгийг “барилгын ажлын зөвшөөрөлгүйгээр” гэж

найруулбал архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зургаа батлуулах зохицуулалттай болно. Барилгын тухай хуулийн 40.1.24 дэх хэсэгт “холбогдох зөвшөөрөлгүйгээр” гэсэн үгийг “барилгын ажлын зөвшөөрөлгүйгээр” гэж найруулах.

-ooOoo-

ХАВСРАЛТ - 1:

БАРИЛГЫН САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЖАГСААЛТ¹³

1. Хууль

1.1. Суурь зохицуулалтын хууль

- 1.1.1. Монгол Улсын Үндсэн Хууль /1992 он/
- 1.1.2. Иргэний хууль /2002 он/
- 1.1.3. Захиргааны ерөнхий хууль /2015 он/

1.2. Барилгын салбарын хууль

- 1.2.1. Барилгын тухай хууль /2016 он/
- 1.2.2. Хот байгуулалтын тухай хууль /2008 он/
- 1.2.3. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /1993 он/
- 1.2.4. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль /2015 он/
- 1.2.5. Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль /2011 он/
- 1.2.6. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай /2003 он/

1.3. Барилгын салбартай холбоотой бусад зохицуулалтын хууль

- 1.3.1. Автозамын тухай хууль /2017 он/
- 1.3.2. Орон сууцны тухай хууль /1999 он/
- 1.3.3. Газрын тухай хууль /2002 он/
- 1.3.4. Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль /1999 он/
- 1.3.5. Геодези зураг зүйн тухай хууль /1988 он/
- 1.3.6. Газрын хэвлийн тухай хууль /1988 он/
- 1.3.7. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (2023),
- 1.3.8. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль (2017); Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль /2021 он/
- 1.3.9. Зөрчлийн тухай хууль /2017 он/
- 1.3.10. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль /2017 он/
- 1.3.11. Зөвшөөрлийн тухай хууль /2022 он/
- 1.3.12. Эрчим хүчний тухай хууль /2001 он/
- 1.3.13. Галын аюулгүй байдлын тухай хууль /2015 он/
- 1.3.14. Хог хаягдлын тухай хууль /2017 он/
- 1.3.15. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тухай хууль /2016 он/
- 1.3.16. Төмөр замын тээврийн тухай хууль /2023 он/
- 1.3.17. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хууль (2018)

1.4. Барилгын салбарын төрийн эрх бүхий байгууллагын хууль

- 1.4.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /1996 он/
- 1.4.2. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль /1993 он/
- 1.4.3. Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль /2004 он/

¹³ БХБСайдын тушаалыг www.legalinfo.mn сайтаас хайхад гарч ирсэн бүх илэрцийг шалгаж холбогдох бүх дүрэм, журам, нормыг оруулав. Мөн БХБЯ болон БХТ-с хамтран гаргасан “Барилгын салбарын эрх зүйн актын эмхэтгэл 2023 он” номноос тулгаж шалгасан бөгөөд хүчингүй болсон дүрэм, журмуудыг оруулаагүй болно.

- 1.4.4. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилсан сэргийлэх тухай хууль /2012 он/
- 1.4.5. Авлигын эсрэг хууль /2006 он/
- 1.4.6. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль /2020 он/

1.5. Барилгын хөдөлмөр эрхлэлттэй холбоотой конвенц, хууль

- 1.5.1. Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай конвенц /1988 он/
- 1.5.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль /2008 он/

2. Улсын Их хурлын тогтоол

- 2.1. Алсын хараа-2050 /Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол/;
- 2.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай /Улсын Их Хурлын 2013 оны 20 дугаар тогтоол/;
- 2.3. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр /Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоол/;
- 2.4. Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл /Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоол/;

3. Засгийн газрын тогтоол

- 3.1. Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх тухай /Засгийн газрын 2018 оны 51 дүгээр тогтоол/
- 3.2. Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо /Засгийн газрын 2019 оны 106 дугаар тогтоол/
- 3.3. Барилгын үйл ажиллагаанд олон улсын байгууллага, гадаадын барилга байгууламжийн норм, дүрэм, стандартыг бүртгэх, хэрэглэх журам /Засгийн газрын 2019 оны 107 дугаар тогтоол/
- 3.4. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм /Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоол/
- 3.5. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм /Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол/
- 3.6. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага, бүртгэх журам /Засгийн газрын 2021 оны 343 дугаар тогтоол/
- 3.7. Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм /Засгийн газрын 2021 оны 213 дугаар тогтоол/
- 3.8. Барилгын ажлын захиалагчийн дүрэм /Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоол/
- 3.9. Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм /Засгийн газрын 2017 оны 353 дугаар тогтоол/
- 3.10. Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарлалтыг шинэчлэн батлах тухай /Засгийн газрын 2023 оны 106 дугаар тогтоол/
- 3.11. Барилга байгууламжийн аюулгүй байдлын техникийн зохицуулалт /Засгийн газрын 2023 оны 97 дугаар тогтоол/
- 3.12. Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого /Засгийн газрын 2019 оны 70 дугаар тогтоол/
- 3.13. Барилгын нэгж талбайн төсөвт өртөг, төсвийн жишиг үнэлгээ /Засгийн газрын 2010 оны 336 дугаар тогтоол/

4. Шадар сайдын тушаал

- 4.1. Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм /Шадар сайдын 2017 оны 78 дугаар тушаал/

4.2. Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам /Шадар сайдын 2021 оны 129 дүгээр тушаал/

5. БХБ-ын Сайдын тушаал

- 5.1. Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах зориулалт, хүчин чадлыг тогтоох журам /БХБСайдын 2021 оны 211 дүгээр тушаал/
- 5.2. Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм /БХБСайдын 2017 оны 200 дугаар тушаал/
- 5.3. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам /БХБСайдын 2021 оны 147 дугаар тушаал/
- 5.4. Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай /БХБСайдын 2022 оны 182 дугаар тушаал/
- 5.5. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам /БХБСайдын 2016 оны 126 дугаар тушаал/
- 5.6. Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм /БХБСайдын 2016 оны 178 дугаар тушаал/
- 5.7. Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам /БХБСайдын 2016 оны 180 дугаар тушаал/
- 5.8. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх экспертэд тавигдах шаардлага, түүнийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, эрх олгох журам /БХБСайдын 2019 оны 213 дугаар тушаал/
- 5.9. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, зөвшөөрөлцөх, экспертиз хийх дүрэм /ЗТБХБСайдын 2011 оны 226 дугаар тушаал/
- 5.10. Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам шинэчлэн батлах тухай /БХБСайдын 2022 оны 134 дүгээр тушаал/
- 5.11. Архитектор, инженерийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам /БХБСайдын 2016 оны 160 дугаар тушаал/
- 5.12. Барилгын материалын туршилт, шинжилгээ судалгааны ажил эрхлэх нэгдсэн лабораторийн дүрэм /БХБСайдын 2016 оны А/193 дугаар тушаал/
- 5.13. Барилгын төсөвчний ёс зүйн дүрэм /БХБСайдын 2017 оны 103 дугаар тушаал/
- 5.14. Барилгын салбарын мэргэжилтэн болон хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх, шинэчлэх, мэдээллийг мэдээллийн санд байршуулах, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах журам /БХБСайдын 2017 оны 66 дугаар тушаал/
- 5.15. Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөлийн дүрэм /БХБСайдын 2017 оны 155 дугаар тушаал/
- 5.16. Барилгын ажлын аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн журам /БХБСайдын 2017 оны 195 дугаар тушаал/
- 5.17. Аргачлал батлах тухай- Тусгай зөвшөөрлийн суурь нөхцөлийг дүйцүүлсэн аргачлал /БХБСайдын 2018 оны 33 дугаар тушаал/
- 5.18. Барилга байгууламжийн норм, нормативын сангийн журам /БХБСайдын 2019 оны 4 дүгээр тушаал/
- 5.19. Барилгын үйл ажиллагаанд холбогдсон зөвшөөрөл олгох хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэх болон барилгын салбарт нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх нийтлэг журам /БХБСайдын 2022 оны 228 дугаар тушаал/
- 5.20. Геодези, зураг зүйн үйлдвэрлэлд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм /БХБСайдын 2022 оны 136, А/125 дугаар тушаал/
- 5.21. Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторын дүрэм /БХБСайдын 2010 оны 155 дугаар тушаал/

- 5.22. Хөдөлмөр зарцуулалтын нэгж хугацааны норм /БХБСайдын 2021 оны 13 дугаар тушаал/
- 5.23. “Цахилгаан техникийн тоноглол хэрэгсэл, хэмжих, шалгах багаж, автоматикийн тохируулга зүгшрүүлэлтийн ажлын төсвийн норм”, “Ус хангамж, ариутгах татуургын байгууламжийн тохируулга, зүгшрүүлэлтийн ажлын төсвийн норм” /БХБСайдын 2016 оны 75 дугаар тушаал/
- 5.24. Ус дулаан хангамж, ариутгах татуургын сүлжээ, үерийн усны байгууламжийн геодизийн ажлын дүрэм /БХБСайдын 2016 оны 25 дугаар тушаал/
- 5.25. Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх тухай / БХБСайдын 2022 оны 123 дугаар тушаал/
- 5.26. Эмнэлгийн зориулалттай барилга төлөвлөх /БХБСайдын тушаал 2021 оны 03 дугаар тушаал/
- 5.27. Эрчим хүчний барилга байгууламж барих ажлын журам /ЭХСайдын 2019 оны 125 дугаар тушаал/
- 5.28. Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх журам /ЭХСайдын 2015 оны 188 дугаар тушаал/
- 5.29. Барилга байгууламжийн эдэлгээний жишиг хугацаа тогтоох дүрэм /БХБСайдын 2023 оны 60 дугаар тушаал/
- 5.30. Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал /БХБСайдын 2018 оны 208 дугаар тушаал/
- 5.31. Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай /БХБСайдын 2022 оны 222 дугаар тушаал/
- 5.32. Барилга угсралтын ажилд мөрдөх барилгын норм ба дүрэм /БХБСайдын 2005 оны 105 дугаар тушаал/
- 5.33. Барилга угсралт, барилга засварын ажлын хөдөлмөр зарцуулалтын норм боловсруулах дүрэм /БХБСайдын 2005 оны 55 дугаар тушаал/
- 5.34. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын төлөвлөлт /БХБСайдын 2022 оны 193 дугаар тушаал/
- 5.35. “Барилгын материалаас дотоод орчны агаарт ялгарах дэгдэмхий органик нэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” болон “Барилгын материалаас дотоод орчны агаарт ялгарах хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” /ЭМС, БХБСайдын 2018 оны А/05, 08 дугаар хамтарсан тушаал/
- 5.36. Барилгын норм ба дүрэм батлах тухай /Усны байгууламжийн буурь/ - /ЗТ,БХБСайдын 2010 оны 107 дугаар тушаал/
- 5.37. Барилгын төсөв зохиох дүрэм /БХБСайдын 2020 оны 30 дугаар тушаал/
- 5.38. “Барилгын ажилтны тарифт цалингийн жишиг”, “Барилгын ажилтны цагийн тарифт цалингийн жишгийг индексжүүлэн хэрэглэх аргачлал” /БХБСайдын 2019 оны 217 дугаар тушаал/
- 5.39. Орон сууц, иргэний ба үйлдвэрийн барилга байгууламжийн газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг үнэлэх, судалгаа явуулах, даацын үндсэн бүтээцийг хүчитгэх, паспортжуулах заавар /БХБСайдын 2000 оны 94 дүгээр тушаал/
- 5.40. "Зураг төслийн баримт бичигт магадлал хийх ажлын гэрээний үлгэрчилсэн загвар", "Зураг төслийн баримт бичигт магадлал хийх иргэн, хуулийн этгээдтэй байгуулах ажил гүйцэтгэх гэрээний үлгэрчилсэн загвар" , "Зураг төслийн магадлалын дардас, тэмдгийн загвар" болон "Зураг төслийн магадлалын дүгнэлтийн үлгэрчилсэн загвар" /БХБСайдын 2016 оны 179 дүгээр тушаал/
- 5.41. Барилга байгууламжийн цахим тооцооллын программ хангамжийг баталгаажуулж, хэрэглэх журам /БХБСайдын 2021 оны 268 дугаар тушаал/
- 5.42. Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын техникийн зохицуулалтын журам /БХБСайдын 2023 оны 98 дугаар тушаал/

- 5.43. Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам /БОНХАЖСайд, БХБСайдын 2015 оны А-230, 127 дугаар хамтарсан тушаал/
- 5.44. Авто зам, замын байгууламжийн барилгын ажилд техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журам /ЗТХСайдын 2018 оны 228 дугаар тушаал/
- 5.45. Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам /БХБСайдын 2020 оны 48 дугаар тушаал/
- 5.46. Барилгын зураг төсөл боловсруулах барилгын норм ба дүрэм /ЗТ,БХБСайдын 2011 оны 256 дугаар тушаал/
- 5.47. Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэл /МУДБХСайдын 2000 оны 09-р тушаал/
- 5.48. Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн сүлжээнд эрсдэлийн үнэлгээ хийх заавар” /ЭМС болон БХБСайдын 2017 оны А/149, 78 тоот хамтарсан тушаал /
- 5.49. Барилгын материалын эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлтийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ /ЭМС болон БХБС-н 2018 оны А/05, 08 тоот хамтарсан тушаал
- 5.50. Газар, үл хөдлөх эд хөрөнгийн нөхөх олговрын зориулалттай үнэлгээний аргачлал /СС болон БХБСайдын 2020 оны 202, 196 дугаар хамтарсан тушаал

---oOo---

Батлав. Хууль зүй, дотоод хэргийн сайд

Ц.Нямдорж

ИРГЭН, ЭДИЙН ЗАСГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАВХАРДАЛ, ЗӨРЧИЛ, ХИЙДЛИЙГ АРИЛГАХ, ТЭДГЭЭРИЙН ХООРОНДЫН УЯЛДАА ХОЛБООГ САЙЖРУУЛАХ АЖЛЫГ ХИЙХ АРГАЧЛАЛ

Нэг. Зорилго

1.1.Энэхүү аргачлалын зорилго нь иргэн, эдийн засгийн хууль тогтоомжид байгаа давхардал, зөрчил, хийдлийг тогтоох замаар тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах, иргэн, хуулийн этгээд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн таатай нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Хоёр. Ерөнхий ойлголт

2.1.Энэхүү аргачлал дахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1.хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах-хууль тогтоомжийг харьцуулан судлах замаар тэдгээрийн давхардал, зөрчил, хийдлийг тогтоон арилгах цогц үйл ажиллагааг;

2.1.2.давхардал-хуулиар нэгэнт зохицуулсан харилцааг хэл зүйн хувьд хуулбарласан, эсхүл тэдгээрийн зохицуулалтын агуулга, зорилго нь ижил байхыг;

2.1.3.зөрчил-ижил субъектуудын зан үйлийг ижил нөхцөлд өөрөөр журамласан, Үндсэн хууль болон органик хуульд заасан журмаас өөр зохицуулалтыг тусгасан, өөр нэр томъёо хэрэглэсэн, зохицуулалтын агуулга нь тухайн хуулийн үзэл баримтлалтай зөрчилдсөн байхыг;

2.1.4.хийдэл-тухайн харилцаанд оролцогчдын зан үйлийг хуульчилсан боловч түүнийг хэрэгжүүлэх арга зам, процедурыг заагаагүй, шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан, эсхүл зохицуулалт нь хэл зүйн найруулгын хувьд зөрчилтэй буюу салаа утгатай байхыг.

Гурав. Уялдаа холбоог сайжруулах ажлыг хийх үндсэн арга

3.1.Хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах /цаашид “уялдаа холбоог сайжруулах” гэх/ ажлыг зохион байгуулахдаа дараахь үндсэн аргыг хэрэглэнэ:

3.1.1. анализ-синтезийн арга;

3.1.2. ярилцлагын арга;

3.1.3.харьцуулалтын арга:

а/бичвэрийн харьцуулалтын арга;

¹⁴ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 84 дугаар тушаалаар батлагдсан “Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах ажлыг хийх аргачлал”

б/агуулгын харьцуулалтын арга.

3.1.4.хууль тогтоомжийн эрэмбэлэлийн арга

3.2.Уялдаа холбоог сайжруулах ажлыг хийхдээ хууль тогтоомжийн бичвэр болон агуулгыг харьцуулах бөгөөд хууль тогтоомж давхардсан, зөрчилдсөн гэж үзвэл түүнийг хууль тогтоомжийн эрэмбэлэлийн аргын дагуу хамгийн дээд хүчин чадалтай буюу суурь харилцааг зохицуулж байгаа хуульд бусад хууль, эрх зүйн актыг нийцүүлэх замаар ажиллана.

Дөрөв. Уялдаа холбоог сайжруулах ажлыг хийх үе шат

4.1.Уялдаа холбоог сайжруулах ажлыг дараахь үе шатаар хийнэ:

4.1.1.бэлтгэл үе шат;

4.1.2.хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг тогтоох үе шат;

4.1.3.хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг системчлэх;

4.1.4.хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг тайлагнах;

4.1.5.хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах замаар тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах санал боловсруулах /хуулийн төсөл/;

Тав.Бэлтгэл үе шат нь дараахь хэсгээс бүрдэнэ.

5.1. Бэлтгэл үе шатанд сонгож авсан хуультай холбоотой дараахь эрх зүйн актыг цуглуулна:

1/ Хууль;

2/ ОУ-ын гэрээ;

3/ УИХ-ын тогтоол;

4/Ерөнхийлөгчийн зарлиг;

5/Үндсэн хуулийн Цэцийн шийдвэр;

6/Улсын Дээд шүүхийн тогтоол;

7/Засгийн газрын тогтоол;

8/ Сайддын тушаал;

9/ Засгийн газрын агентлагийн даргын тушаал;

10/УИХ-аас томилогддог байгууллагын дарга, түүнтэй адилтгах албан тушаалтны шийдвэр.

5.2.Цуглуулсан хууль, хуульчилсан актаасаа хүчинтэй үйлчилж байгааг нь ялгах: Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон актын хүчин төгөлдөр эсэхийг тогтоохдоо Засгийн газрын 2003 оны 8 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга, агентлагийн даргын нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг хянаж бүртгэх журам”-ын дагуу Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлсэн эсэхийг удирдлага болгоно.

5.3.Цуглуулсан хууль, хуульчилсан актаа уншиж танилцаад эдгээрээс тухайн хуультай шууд холбогдох хууль, хуульчилсан актыг ялгаж авах;

Зургаа.Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг тогтоох үе шат

6.1. Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг тогтоох үе шатанд тухайн хуультай шууд холбогдох хууль, хуульчилсан акттай сонгож авсан хуулийн заалт бүрийг харьцуулж хүснэгтлэнэ.

6.2.Хүснэгтийн дагуу энэхүү аргачлалын 7.1-7.3-т заасан шалгуурын дагуу заалт тус бүрээр нь харьцуулан уншиж давхардал, зөрчил, хийдлийг тогтоох.

Долоо. Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг тогтоох

7.1.Хууль тогтоомжийн давхардлыг дараахь асуудлыг харгалзан үзсэний үндсэн дээр тогтооно:

7.1.1.тухайн хуульд байгаа зохицуулалтын бичвэрийг бусад хуульд давтан хуулбарлан хуульчилсан эсэх;

7.1.2.тухайн хуульд байгаа зохицуулалтыг уг хуульд болон бусад хуульд агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан эсэх;

7.1.3.төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг хуульд давхардуулан хуульчилсан эсэх;

7.1.4.тухайн хуулийн тодорхой зохицуулалтыг Улсын дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний давхардалыг арилгахад чиглэгдсэн эсэх.

7.2.Хууль тогтоомжийн зөрчлийг дараахь асуудлыг харгалзан үзсэний үндсэн дээр тогтооно:

7.2.1.тухайн зохицуулалт нь хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;

7.2.2.хууль тогтоомжийн хэсэгт заасан хуулийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;

7.2.3.хуулийн зүйлийн нэр тухайн зүйлд байгаа хэсэг, заалтын агуулгын нийлбэртэй нийцэж байгаа эсэх;

7.2.4.хуулийн зүйл, заалт, зохицуулалт нь хэл зүйн найруулгын хувьд салаа утгатай эсэх;

7.2.5.хуульд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн болон бусад хуулийн нэр томъёотой зөрчилдөж байгаа эсэх;

7.2.6.тодорхой асуудлыг тухайн хуулиар зохицуулахаар заасан боловч уг асуудлаар өөр журмыг өөр хуульд заасан эсэх;

7.2.7.хуульд заасан эшлэл алдаатай эсэх;

7.2.8.тухайн хуульд бусад хуулиас авсан эшлэлийн дугаар нь нөгөө хуульд байгаа зохицуулалттай нийцэж байгаа эсэх;

7.2.9.татварынхаас бусад хуульд тогтоомжид албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;

7.2.10.тухайн хуульд тусгай зөвшөөрөл олгохоор заасан нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд туссан эсэх;

7.2.11.өмчлөх эрхийг хязгаарласан буюу хязгаарлахад чиглэгдсэн эрх зүйн акт гаргах эрхийг бусад этгээдэд хуулиар олгосон эсэх;

7.2.12.тухайн хуулийн тодорхой зохицуулалтыг Улсын дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний зөрчлийг арилгахад чиглэгдсэн эсэх.

7.2.13.тухайн хуулийн зүйл, заалт өөр хуулийн заалттай зөрчилдөж буй эсэх

7.3.Хууль тогтоомжийн хийдлийг дараахь асуудлыг харгалзан үзсэний үндсэн дээр тогтооно:

7.3.1. тухайн хуульд тодорхой харилцааг нарийвчлан хуулиар зохицуулахаар заасан бол уг нарийвчилсан зохицуулалт бүхий хууль батлагдсан эсэх;

7.3.2. тухайн хуульд тодорхой харилцааны нарийвчилсан зохицуулалтыг батлах эрхийг төрийн бусад байгууллагад шилжүүлсэн бол уг нарийвчилсан зохицуулалт батлагдсан эсэх;

7.3.3. тухайн хуульд заасан процедурын шинжтэй зохицуулалт нь ойлгомжтой, тасралтгүй үргэлжлэх боломжтой байдлаар томъёолсон эсэхийг тодорхойлох;

7.3.4. тодорхой эрх, үүргийг хэрэгжүүлэх субъект нь тодорхой эсэх;

7.3.5. төрийн байгууллага, албан тушаалтнаас тодорхой асуудал шийдвэрлэхээр хуульд заасан бол уг асуудлыг шийдвэрлэх хугацааг тодорхой заасан эсэх;

7.3.6. хуульд заасан хориглосон зохицуулалт нь түүнийг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх;

7.3.7. тухайн хуулийн тодорхой зохицуулалтыг Улсын дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний хийдлийг арилгахад чиглэгдсэн эсэх.

7.3.8. хуульд байх шаардлагатай зохицуулалт тусгагдсан эсэх

7.3.9. хуулийн зүйл, заалт, зохицуулалт нь ойлгомжтой байгаа эсэх;

7.4. Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг тогтоох ажлын хүрээнд иргэн, хуулийн этгээд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дараахь асуудлыг судалсан байна:

7.4.1. иргэдээс аливаа бичиг баримт, тайлан мэдээ авахаар заасан хуулийн зохицуулалтыг нарийвчлан тодорхойлж уг баримт, тайлан мэдээ гаргуулах ач холбогдлыг талаар хуулийн хувийн хэргээс тодруулах, уг тайлан мэдээний ашиглалт, хэрэглээний талаархи мэдээллийг уг тайланг хүлээн авсан эрх бүхий байгууллагатай уулзаж мэдээлэл авах, шаардлагатай гэж үзвэл эдийн засгийн тооцооллыг хийх;

7.4.2. төрийн байгууллага, албан тушаалтнаас тодорхой асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах хуульд заасан хугацааг тогтоох, энэ хугацаа нь өргөдөл, гомдлын хуульд заасан нийтлэг журамд нийцэж байгаа эсэхийг шалгах;

7.4.3. тухайн харилцаанд оролцогч нь гадаадын хөрөнгө оруулагч гэдэг үндэслэлээр өөр журам тогтоосон эсэх, ийнхүү тогтоосон журам нь дотоодын хөрөнгө оруулагчаас дутуугүй нөхцөл олгож байгаа эсэхийг судлах.

Найм.Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг системчлэх үе шат

8.1. Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг тогтоосны дараа тэдгээрийг системчлэнэ.

8.2. Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг хууль тус бүрээр системчлэх бөгөөд хууль тогтоомжийн тодорхой зүйл, хэсэг, заалт бичвэрийн хувьд болон агуулгын хувьд давхардсан, зөрчилдсөн бол эрэмблэлийн хувьд дээд хүчин чадалтай, эсхүл суурь харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжид бусад хууль тогтоомжийг нийцүүлэх чиглэл баримтална.

Ес.Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг тайлагнах үе шат

9.1. Тайланг хууль тус бүрээр ажлын хэсгийн гишүүдийн саналыг нэгтгэн гаргана. Тайланг товч, тодорхой, албан хэргийн бичгийн найруулгындагуу бичсэн байна.

9.2. Тайлан нь дараахь хэсгээс бүрдэнэ.

а/танилцуулга;
б/дүгнэлт;
в/санал.

9.3. Танилцуулга хэсэгт дараахь асуудлыг тусгана:

- судалсан хуулийн нэр;
- судалсан хуулинд хамаарах бусад хууль тогтоомж, эрх зүйн актын тоо, төрөл;
- судалгаанд хэрэглэсэн арга;
- тухайн хууль батлагдсан нөхцөл байдал, хэрэгжилтийн талаархи товч танилцуулга.

9.4. Дүгнэлт хэсэгт дараахь асуудлыг тусгана:

- судалгааны явцад тогтоосон давхардал, ийнхүү давхардсан гэж тооцох болсон үндэслэл;
- судалгааны явцад тогтоогдсон зөрчил, ийнхүү зөрчилдсөн гэж үзэх болсон үндэслэл;
- судалгааны явцад тогтоогдсон хийдэл, ийнхүү хийдэл гэж үзэх болсон үндэслэл.

9.5. Саналын хэсэгт дараахь асуудлыг тусгана:

- судалгааны явцад тогтоогдсон давхардал, хийдэл, зөрчлийг хэрхэн арилгах боломжтой тухай санал;
- хэд хэдэн хууль хоорондоо давхардсан эсхүл, зөрчилдөж байгаа бол аль хэм хэмжээг авч үлдэх нь зохимжтой байгаа талаархи санал, түүний үндэслэл;
- тодорхой хуулийг хүчингүй болгох санал дэвшүүлсэн тохиолдолд ийнхүү хүчингүй болгохоор дэвшүүлж байгаа саналын үндэслэл /зорилгоо биелүүлсэн, нийгмийн шаардлагад нийцэхгүй байгаа, хэрэглэгдэхгүй болсон, 50 ба түүнээс дээш хувь нь бусад хуулийн зохицуулалттай давхардаж байгаа гэж мэт/.

9.6. Тайланд дараахь материалыг хавсаргана:

- тухайн хуультай холбогдох хууль тогтоомж болон эрх зүйн актын жагсаалт;
- судалгаанд ашигласан материал;
- судалгааны явцад зохион байгуулсан хурал, зөвлөгөөн, уулзалтын тэмдэглэл;
- давхардал, хийдлийг тогтоох зорилгоор боловсруулсан энэ журмын 6.1-д заасан харьцуулалттай хүснэгт;
- шаардлагатай гэж үзсэн бусад материал.

9.7. Тайланг ХЗДХЯ-нд бичгээр болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

9.8. Шаардлагатай гэж үзвэл ажлын хэсэг ХЗДХЯ хамтран тайланд тодруулга болон нэмэлт хийж болно. Энэ тухайгаа тайланд заавал тусгана.

Арав.Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах замаар тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах санал боловсруулах /хуулийн төсөл/ үе шат

10.1. ХЗДХЯ ажлын хэсгийн гаргасан тайлангийн саналд үндэслэн хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах чиглэлээр холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг боловсруулна.

---oOo---